



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ



ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ



ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНД,  
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ


# 18 САРТАЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ЦОГЦ ҮЗЛЭГ ХИЙХ ГАРЫН АВЛАГА

18 САРТАЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ЦОГЦ ҮЗЛЭГ ХИЙХ ГАРЫН АВЛАГА



“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.  
Утас: 319658, 70140459  
Вэб хаяг: www.munkhiin-useg.mn

ISBN 9919-9519-1-9



9 789919 951917



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ



ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ



ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНД,  
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

# 18 САРТАЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ЦОГЦ ҮЗЛЭГ ХИЙХ ГАРЫН АВЛАГА

2019 он

ННА 74.3  
ДАА 371.9  
А-714

Энэхүү ном нь Монгол Улсын “Зохиогчийн эрхийн тухай” хуулиар баталгаажсан тул эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх, цахим болон бусад хэлбэрээр хувиран олшруулах, түгээн тараахыг хориглоно.

Цаасны хэмжээ: В5  
Хэвлэлийн хуудас: 6.3 х.х

“Мөнхийн Үсэг” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ISBN: 978-9919-9519-1-7

# ГАРЧИГ

Удиртгал.....	5
<b>НЭГ. 18 Сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг .....</b>	<b>7</b>
1. Зорилго.....	7
2. Зорилт.....	7
3. Үзлэгийн хамрах хүрээ.....	7
4. Үзлэг хийхэд зайлшгүй шаардлагатай хэрэгслүүд .....	7
5. Үзлэг хийх эмчийн анхаарах зүйлс .....	8
6. Эрүүл мэнд хөгжлийн цогц үзлэгийн маягтыг бөглөх .....	8

<b>ХОЁР. Хүүхдийн хөгжлийн үзүүлэлтүүд, хөгжлийг үнэлэх арга болон гэр бүлд зөвлөгөө өгөх .....</b>	<b>24</b>
1. Өөрөө алхаж чадаж байгаа юу? .....	24
2. Утгатай үг, жишээ нь “Эж”, “Аав” гэж хэлдэг үү? .....	25
3. Аяганаас өөрөө ууж чаддаг уу? .....	26
4. Угжаар хооллодог уу? (Шүд кооролтоос сэргийлэхийн тулд угжаар хооллохыг зогсоох шаардлагатай).....	27
5. Тогтсон цагт хооллодог уу? .....	28
6. Нүд нь хэвийн бус хөдөлдөг, эсвэл гэрэлд хэт гялбадаг уу?.....	29
7. Хүний нүд рүү эгцэлж хардаг уу? .....	30
8. Араас нь нэрээр нь дуудахад эргэж хардаг уу? .....	31
9. Шүдээ угаахыг зааж өгөхөд дуурайж байна уу? .....	31
10. Хүүхэд ямар зүйл оролдох дуртай вэ? .....	33
11. Мэддэг зүйлийг нь асуухад хуруугаараа зааж чадаж байна уу?.....	34
12. Биеийн эрхтнээ мэддэг үү? Жишээ нь “Амаа ангай”, “Хэлээ гарга” гэхэд ойлгох уу? .....	35
13. Бусад хүүхэдтэй хамт тоглодог уу? .....	35
14. Таньдаг хүнтэйгээ ярих дуртай юу?.....	36
15. Тэврэхэд өөдөөс тэвэрдэг үү? .....	38
16. Аав ээжтэйгээ тоглохдоо инээдэг үү? Чангаар инээж хөхөрдөг үү?.....	38

<b>ГУРАВ.18 Сартай хүүхдийн хөгжлийн онцлог ба хөгжлийг дэмжих арга зүй...</b>	<b>39</b>
1. 18 Сартай хүүхдийн хөгжил .....	39
2. 18 Сартай хүүхдийн биеийн болон сэтгэхүйн хөгжилд анхаарах асуудал ба томчуудын оролцоо .....	43
3. Асран хамгаалагчдын асуултад хариулах.....	50
<b>ХАВСРАЛТ 1.</b> 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн маягт .	55
<b>ХАВСРАЛТ 2.</b> Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн ээлжит үзлэгт дэмжлэгт хяналт хийх удирдамж.....	64
<b>ХАВСРАЛТ 3.</b> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал .....	73

## УДИРТГАЛ

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) хамтран “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах” төслийг 2015 оны 8 дугаар сараас хэрэгжүүлж байна. Үүний тулд хүүхэд бүрийг тодорхой насанд нь эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамруулж эрсдэлтэй хүүхдийг илрүүлэн холбогдох тусламж, үйлчилгээ болон хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай. “Цогц үзлэг” гэдгийн учир нь хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийг хамтад нь үнэлнэ гэсэн үг юм.

18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн зорилго нь хүүхэд бүрийн эрүүл мэнд, өсөлт, хөгжлийг тандах замаар хүүхэд бүрийн эрүүл өсөлт хөгжлийг дэмжих бөгөөд хөгжлөөр хоцорч байгаа хүүхдийг аль болох эрт үед нь таньж мэдсэнээр хүүхэд болон гэр бүлд шаардлагатай дэмжлэгийн үйлчилгээнд холбох явдал юм. Үе тэнгийн хүүхдүүдийг тухайн насанд нь тохирсон асуумжийн дагуу нэгдсэн журмаар үзлэгийг зохион байгуулснаар тэдгээр хүүхдүүдийг өөр хооронд нь харьцуулж, хөгжлийн үзүүлэлтийг дүгнэх боломж бүрддэг.

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т хүүхдийг 18 сар, 30-36 сартайд нь эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамруулж илэрсэн хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд дэмжлэг үзүүлэх удирдамж боловсруулж хэрэгжүүлэх; Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т “...хүүхэд бүрийг ...хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд тогтмол хугацаанд хамруулах”; гэсэн заалтуудын дагуу гаргасан Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын А/304, А/699, А/460 тоот хамтарсан тушаалд “... Өрх, сумын эрүүл мэндийн төвд 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг тогтмол зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасан байна.”<sup>1</sup> Эдгээр заалтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тус төслийн хүрээнд, нийслэлийн Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв, Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын удирдлага дор 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг зохион байгуулах талаар холбогдох эмч нарыг сургалтад хамруулж үзлэгийг сар бүр зохион

<sup>1</sup> Хавсралт 3

байгуулж байна. Үзлэгийн явцад эмнэлгийн мэргэжилтнүүдэд зайлшгүй шаардлагатай гарын авлагыг боловсруулав.

Энэ нь хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг тогтмол зохион байгуулах чиг үүрэг бүхий өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүдэд зориулагдсан боловч хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн бүх байгууллагад ашиглах боломжтой.

Нэгдүгээр бүлэгт, 18 сартай хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн зорилго болон зохион байгуулах аргын талаар тайлбарласан. Энэ бүлэгт, хүүхдэд бодит үзлэгийг ямар дэс дарааллаар хэрхэн хийх, үзлэгийн маягтад хэрхэн тэмдэглэх талаар тодорхой тусгасан.

Хоёрдугаар бүлэгт, үзлэгийн маягт дахь “Хүүхдийн хөгжлийн үзүүлэлтүүд”-ийг ай тус бүртэй холбон дэлгэрэнгүй тайлбарлаж, хөгжлийг шалгах аргууд, эцэг эхэд зөвлөгөө өгөх талаар нарийвчлан тусгасан болно.

Гуравдугаар бүлэгт, 18 сартай хүүхдийн хөгжлийн онцлог ба тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажиллах арга зүй, бага насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдаас нийтлэг асуудаг асуултууд, хариулт зэргийг оруулав.

Хавсралт 1-т 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн маягыг, Хавсралт 2-т Үзлэгт дэмжлэгт хяналт хийх удирдамжийг, Хавсралт 3-т ХНХ, БСШУС, ЭМ-ийн сайд нарын А/304, А/699, А/460 тоот хамтарсан тушаалын заалтуудыг тусгасан болно. Дэмжлэгт хяналтыг тодорхой хугацаагаар зохион байгуулах нь эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн чанарыг сайжруулах, улмаар хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд чухал ач холбогдолтой юм.

Та бүхэн энэхүү гарын авлагыг ашиглан 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг өөрсдийн орон нутаг, байгууллагад зохион байгуулснаар Монголын хүүхэд багачуудын эрүүл ирээдүйг цогцлооход тодорхой хувь нэмэр оруулах болно.

# 1 18 САРТАЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ЦОГЦ ҮЗЛЭГ

## 1. ЗОРИЛГО

Энэхүү үзлэгийн зорилго нь хүүхдийг тодорхой насанд нь нэгдсэн журмаар цогц үзлэгт хамруулснаар аливаа өвчин, эмгэг, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлж, эмчлэн эрүүлжүүлэх, хөгжлийг дэмжих арга хэмжээ авахад оршино.

## 2. ЗОРИЛТ

Үзлэгээр хүүхдийн а) эрүүл мэнд, б) өсөлт, в) хөгжлийг цогцоор нь үнэлж, илэрсэн эмгэгийг эмчилж, эрүүлжүүлэх, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх, хоцрогдолтой хүүхдийг зохих үйлчилгээнд илгээх боломж бүрдэнэ.

## 3. ҮЗЛЭГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Тухайн нутаг дэвсгэрт (баг, сум, хороо) амьдарч байгаа 18 сартай бүх хүүхэд хамрагдах ба энэ нь 18 сартайгаас 18 сар 29 хоногтой хүүхэд юм.

## 4. ҮЗЛЭГ ХИЙХЭД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ХЭРЭГСЛҮҮД

- Харьяалах хүрээний 18 сартай хүүхдийн бүртгэл
- Биеийн жин хэмжигч
- Биеийн урт, өндөр хэмжигч
- Туузан метр
- Амьсгал тоологч эсвэл секундын зүүтэй ханын цаг
- Зүрхний цохилт тоолох секундын зүүтэй цаг
- Чагнуур
- Шугам
- Үзлэгийн бээлий
- Хэл дарагч эсвэл шүдний толь
- Чихний дуран /нэг удаагийн хуванцар лүүзтэй/
- Гар ариутгагч
- Шүдний сойз (үзлэгт ирэхдээ сойз авч ирэхийг эцэг эхэд урьдчилж сануулна)
- Аяга
- Хүүхдэд уулгах цэвэр ус
- Тоглоом эсвэл зурагтай ном
- Үзгэн гэрэл



## 5. ҮЗЛЭГ ХИЙХ ЭМЧИЙН АНХААРАХ ЗҮЙЛС

- 18 сартай хүүхдийн үзлэгт хамрагдах хүүхдийг ирэх өдөр үзлэгийн маягтыг хүүхдийн тоогоор бэлтгэж, үзлэгт шаардлагатай зүйлс бэлэн эсэхийг ШАЛГАНА.
  - Насны ангиллыг зөв тогтооно. Тухайн үзлэг хийх өдөр 18 сарт хүрч байгаа хүүхдийг үзлэгт урих ба ямар нэг шалтгаанаар өмнөх үзлэгээс хоцорсон хүүхдийг нөхөж үзлэгт хамруулна.
  - Хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагчтай мэндэлж, урьж суулган, эелдэг харьцана.
  - Асуултыг эцэг эх, хүүхдэд ойлгогдохоор асуух ба хэрэв ойлгохгүй байгаа бол тайлбарлаж өгнө.
  - Үзлэгийг хүүхдийг аль болохоор тайван (уйлаагүй, хөхөө хөхөөгүй) байгаа үед эхлээд амьсгал, зүрхний цохилтыг тоолж, тэр даруйд үзлэгийн маягтад тэмдэглэнэ.
  - Амны хөндийн үзлэг, чихний үзлэгийг хүүхдэд ХАМГИЙН СҮҮЛД ХИЙНЭ.
  - Үзлэг хийх бүртээ ГАРАА УГААХ БА гар ариутгагчийг хэрэглэж, үзлэг хийнэ.
  - Эмнэлзүйн үзлэг хийхдээ бээлий өмсөж болно.
  - Үзлэг дууссаны дараа үзлэгийн хуудсаа шалгаж, дутуу зүйл байгаа эсэхийг нягталж, хамгийн арын хуудас дахь зөвлөгөөг ЭХЭМД–т нь бичиж асран хамгаалагчид нь тайлбарлаж өгнө.
- Үзлэгийн маягт нь тухайн хүүхдийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ба хөгжлийн хөтөлбөрт хамруулах баримт бичиг юм.

## 6. ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ЦОГЦ ҮЗЛЭГИЙН МАЯГТЫГ БӨГЛӨХ

### 6.1 ХҮҮХДИЙН МЭДЭЭЛЭЛ

- Хүүхдийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, хүүхдийн нэрийг бүтэн бичнэ. Хүүхдийн регистрийн дугаарыг бичнэ.
- Гэрийн хаягийг байнгын оршин суудаг хаягаар тодорхой бичнэ.
- Эцэг, эхийн эсвэл тухайн хүүхдийг асрамжилж байгаа холбогдох байгууллагын утсыг тэмдэглэнэ.
- Хүүхдийн төрсөн огноо ба үзлэг хийсэн огноог он/сар/өдөр гэсэн дарааллаар, оны сүүлийн 2 тоогоор бичнэ.
- Тохирох хүйсийг дугуйлж зурна.
- Хүүхдийн насыг нас, сар, хоног гэдгийн харалдаа тоог нь бичнэ.

### 6.2 ЭХИЙН МЭДЭЭЛЭЛ

- Эхийн регистрийн дугаар
- Эхийн нэр: Хүүхдийн төрсний гэрчилгээн дээр байгаа эхийн нэр
- Яс үндэс

- Эрхэлдэг ажил
- Мэргэжил
- Боловсрол
- Гэр бүлийн байдал
- Ам бүл
- Архи, тамхи хэрэглэдэг эсэхийг асууж тийм үгүй гэсний аль нэгийг ✓ тэмдэглэнэ.

### 6.3 ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Үүнд дараах асуултыг асууж бөглөнө. Үүнд:

- Урд нь өвчилж байсан өвчин
  - Халдварт өвчнөөр өвчилсөн эсэх
  - Мэс засал хийлгэсэн эсэх
  - Цусны бүлэг, резус тохироо
  - Нөхрийн эрүүл мэндийн байдал
  - Эхийн жирэмслэлтийн түүх
  - Хүүхдийн төрөлтийн түүх
  - Хүүхдийн урд нь өвчилж байсан өвчин
  - Хүүхэд халдварт өвчнөөр өвчилж байсан эсэх
- Дээрх асуумжийг бөглөсний дараа үзлэгээ хийж эхэлнэ.

### 6.4 ХҮҮХДЭД ХЭМЖИЛТ ХИЙХ

Үзлэгт ирсэн хүүхдүүдийг зохицуулахтай холбоотойгоор хэмжилтийг бодит үзлэг хийхийн өмнө эсвэл хамгийн сүүлд хийж болно.

- Хэмжилт хийх багажнуудаа шалгана.
- Багцын жин ашиглах нь хамгийн үр дүнтэй хэмжилт болно.
- Хэмжилт хийх өрөө гэрэлтүүлэг сайтай, дулаан байна.
- Хүүхдийн дотуур хувцаснаас бусад хувцсыг ЗААВАЛ тайлна.
- Хэмжилт хийхдээ хүүхдийг зөв байрлуулахад анхаарах нь чухал.
- Нэг арга барилаар хэмжинэ.  
Хэмжилт хийхдээ:
- Хүүхдийн жин, урт/өндрийг хэмжинэ.
- Өсөлтийн муруй дээр тэмдэглэнэ.
- Өсөлтийн үнэлгээг бичнэ.
- Өсөлтийн үнэлгээний дүнг тайлбарлана (Зөвлөгөөг ард тусад нь өгнө).
- Хоёр хүртэлх насны хүүхэд босоо байдалд биеэ эгцлэх чадвар сул байдаг тул хэвтүүлж уртыг, харин 2-оос дээш насны хүүхдийг эгц босоо зогсоож өндрийг хэмжинэ.

## 6.5 ХҮҮХДИЙН ХООЛЛОЛТ

- Хүүхдийн хооллолтын байдлыг асууж бичнэ.
- Хөхөө хөхдөг эсэх
- Нэмэгдэл хоол хэдэн удаа, ямар хэмжээтэй иддэг, нэр төрөл.

Үүнд:

Нэг удаад ямар хэмжээтэй аягаар ямар хоол иддэг, шаардлагатай бол өчигдрөөс одоог хүртэл яг юу идсэн гэдгийг асууна. Хэдийд, ямар хоол, ямар хэмжээтэй идсэн г.м.

## 6.6 ЭМНЭЛ ЗҮЙН БОДИТ ҮЗЛЭГ ХИЙХ

Хүүхдэд биеийн ерөнхий үзлэг хийхдээ эрхтэн тогтолцоо бүрт эхлээд шинжүүдийг сайтар шалгаж нягталсны дараа ямар ч эмгэг илрээгүй бол хэвийн, ямар нэг эмгэг өөрчлөлт илэрвэл хэвийн бус гэдгийг сонгон [√] гэж тэмдэглэнэ.

Хэвийн бус шинж байвал тухайн шинжийн урд талын нүдэнд [√] гэж тэмдэглэх ба хүүхдэд илэрсэн шинж үзлэгийн маягтад байхгүй бол бусад гэдгийг тэмдэглэж, ард нь тайлбар бичнэ.

### 6.6.1 Арьс, үс, хумсыг үнэлэх

#### Асуух:

Арьсны үрэвсэл, тууралт, нуралт, загатнаж мааждаг эсэхийг асууна. Хуйхны үрэвсэл, загатнаа, мөөгөнцөр, хумс хугардаг зэргийг тодруулж асууна.

#### Ажиглах ба тэмтрэх:

- **Арьсны өнгө, шарлалт, хөхрөлт, гэмтэл байгаа эсэх,**
- Нуралттай эсэх,
- Судас, зөөлөн эдийн хавдар байгаа эсэх,
- Арьсны тууралтын хэмжээ, байрлал, өнгө, тууралтын шинж чанар,
- Арьсны зарим хэсэгт нөсөөгүй болсон эсэх зэргийг ажиглах,
- Алганы зураас, алганы хөндлөн зураас цөөн эсвэл хэт олон эсэхийг ажиглаж тэмдэглэнэ.
- Арьсны уян чанарыг тодорхойлохдоо эрхий, долоовор хуруугаар хэвлийн дээр босоо шугам үүсгэн арьсыг арьсан доорх өөхөн эдийн хамт 1 секунд чимхээд гараа тавина.
- Шилбэ, шагайн дээр 5-10 секунд чанга дарж, хаванг тодорхойлно.
- Хумсны ургалт, халбаган хумс, цайсан, хөхөрсөн, цусархаг тууралттай, босоо ба хөндлөн шугамтай эсэхийг ажиглаж тэмдэглэнэ.
- Үсний ургалт хэт их, сийрэг, хугарамтгай эсэх, үс нь халцарсан эсэх,
- Хуйх жигд, хуурайшаагүй, шарх сорвигүй эсэх, (мөөгөнцөр байж болзошгүйг анхаарах)

Хэвийн арьс нь тууралтгүй, чийглэг, дулаан, уян чанараа алдаагүй, толигор, зөөлөн байна. Арьсны өнгө нь цагаанаас бор байна. Харин алга, хөлийн ул шар байвал эмгэг гэж үзнэ.

**Жич:** Хэрэв хүүхдийн 2 хөл хавантай байвал, яаралтай эмнэлэгт хэвтэхийг зөвлөнө.

Арьсны тууралтыг цусархаг, бэржрүүт, харшлын гэж тэмдэглэх ба атопик дерматит /диатез/-ийг харшлын гэж үзнэ.

Томдсон өмдний шинжийг “ХӨЦМ”-ийн дагуу тодорхойлно.

Алганы зураасны өөрчлөлтийг хөндлөн, цөөн байна уу гэдгийг харна.

### 6.6.2 Цус багадалтын шинж (Anemia)

#### Ажиглах:

Гарын алга цайвар, хувхай цагаан байна уу? Арьс цайсан байна уу? Салст (нүдний аньсаганы дотор тал) цайсан байна уу? Хумсны толио цагаан байна уу?

5 хүртэлх насны хүүхдийн гарын алгыг өөрийнхөө эсвэл эхийнх нь гарын алгатай харьцуулж харна. Гарын хуруунуудыг арагш нь албадаж тэнийлгэж болохгүй. Цус багадалтын шинжийг “ХӨЦМ”-ийн дагуу тодорхойлно.

### 6.6.3 Толгой, хүзүү, захын тунгалгийн булчирхайг үнэлэх

#### Ажиглах ба тэмтрэх:

Хүүхдийн хүзүүнээс дээш хэсгийг ажиглаж хэвийн харагдаж байгаа эсэх, толгойгоо дааж байгаа, толгой хэвийнхээс том, эсвэл жижиг, усжсан, хүзүү гилжийсэн эсэхийг ажиглаж тэмдэглэнэ

Томорсон эмзэглэлтэй тунгалгийн булчирхай байгаа эсэхийг асууна.

Хүүхдийн дагзны, чихний арын, эрүүн доорх, оочны, хүзүүний ар ба өмнөх, суга, тохой, цавины тунгалгийн булчирхайг тэмтэрч, хэлбэр, хэмжээ, бүтэц (хатуу, зөөлөн), гадаргуу (гөлгөр, барзгар), хөдөлгөөн (хөдөлгөөнтэй, үгүй), наалдац (наалдацтай, үгүй), эмзэглэл (эмзэглэлтэй, үгүй) зэргийг үзэж тэмдэглэнэ.

Эрүүл хүүхдэд хүзүүний ар ба өмнөх, суга, цавины булчирхай тэмтрэгдэж болох ба эдгээр нь цөөн тооны, жижигхэн, зөөлөн, гөлгөр, хөдөлгөөнтэй, хоорондоо ба орчны эдтэй наалдаагүй, эмзэглэлгүй байна.

### 6.6.4 Яс, булчингийн тогтолцоо

#### Асуух:

Гар хөлөө чөлөөтэй хөдөлгөж чадаж байна уу? Өвдөлт хөндүүрлэлт байна уу? Хөшингө байна уу? гэх зэргийг асууж тодруулна.

**Ажиглах ба тэмтрэх:**

Биеийн ерөнхий галбир, биеийн хэсгүүд, мөчнүүдийн харьцаа, араг ясны хөгжлийг зогсоо, суугаа, хэвтээ байрлалд ажиглана.

Мөчдийн хөдөлгөөний чөлөөтэй эсэхийг үзнэ. Булчингийн хүч, хүчдэл, сулралыг 2 талд харьцуулж үзнэ. Үений хөдөлгөөн, хэлбэр өөрчлөгдсөн эсэх, хавдар, булчингийн хатингиршил, өвдөлт, халуун, хаван байгаа эсэхийг үзэж тэмдэглэнэ.

Өрөөн дотор алхуулж, алхаа гишгээг ажиглана. Ганцаараа хөл дээр зогсож чадаж байна уу? Том том зайтай, дэвхэцсэн маягийн, чирсэн, доголж явж байгаа эсэхийг шалгана.

Хэвийн үед биеийн байрлал шулуун, биеийн жин биеийн бүх хэсэгт ижил хуваарилагдсан, хөл, толгойн нэг чигт, хөлний хуруу гадагшаа чиглэлд байна.

Хэвийн үед мөр, дал, ташаа тэгш хэмтэй байна.

**Цээж.** Хүүхдийн цээжний хэлбэр, эгэм, хавиргануудын байрлал, өвчүү зэргийг ажиглана. Үүнд:

- “Шувуун цээж”: Цээж өвчүүний дээд хэсгээр төвгөр, доод хэсгээр хотойсон
- “Туталчны цээж”: Цээж өвчүүний хэсгээр хотойсон
- “Сампингийн эрх”-ийн шинж: Өвчүүнээс гадагш хавирганы байрлал дагуу хуруугаар тэмтрэхэд хавирганы төгсгөлийн мөгөөрсөн хэсэг хөхний шугамаар овойсон байдаг.

**Муруй эгэм.** Хүүхдийн 2 эгмийг харьцуулж харахад эгэм муруйсан эсэхийг ажиглана.

**Нуруу:** Хүүхдийг цэх зогсоож, араас нь сээр нурууны сэртэнгүүд нэг шугаманд зөв байрласан эсэх, сээр нурууны хотойлтуудыг ажиглана.

- Сколиоз - Нурууны нэг буюу хэд хэдэн нугалмай мурийх
- Кифоз - Нуруу бөгтийх
- Лордоз - Нуруу хотойх

**Хөлийн шилбэ:** Хөлийн шилбээр О хэлбэртэй, эсвэл Х хэлбэртэйгээр муруйсан эсэхийг ажиглана.

**Булчин:** Булчингийн хөгжил, хүчдэл, хүч, хөдөлгөөний цар хүрээг тодорхойлно.

Булчингийн хүчдэлийг хөл гарыг нь нугалж, тэнийлгэж үзнэ. Булчингийн хүчдэл ихэссэн үед үений хөдөлгөөн хязгаарлагдмал, хөшингөдүү байдаг бол суларсан үед хөдөлгөөн нь хэт ихэссэн байна. Хэвийн үед тохойны үе  $180^{\circ}$ , түнхний үеэр нугалсан үед өвдөг  $150^{\circ}$  тэнийдэг. Хүүхдийн булчингийн хүчдэлийг тоглоом, бусад зүйлийг бариулаад түүнийг нь чангаах, нугалсан гарыг нь тэнийлгэх гэх мэт эсрэг хөдөлгөөн хийлгэхэд түүнд үзүүлж буй эсэргүүцлээр нь тодорхойлж болно

18 сартай хүүхдийн булчингийн хүчдэлийг тодорхойлохдоо хүүхдээ хэвтүүлээд гарыг бугуйгаар нь атган татахад эхлээд гараа тэнийлгээд дараа нь тохойгоороо нугалан өндийнө. Хэрвээ булчингийн хүчдэл сул бол гараа тохойгоороо нугалахгүй, чанга бол гараа тэнийхгүй.

### 6.6.5 Нүд

#### Асуух:

- Хялар хардаг уу? Хэзээ хялар харж эхэлсэн бэ? Тогтмол ба үе үе /тасалданги/ хялар хардаг уу? Гэр бүлд нь хялар болон нүдний эмгэгтэй хүн байгаа юу?
- Гадаа хурц наранд нэг нүдээ аньдаг уу?
- Нулимс гоождог уу? Нүд нуухтаж байна уу?
- Зовхины буулт хэзээ үүссэн бэ? Олдмол уу, төрөлхийн үү?

#### Ажиглах ба тэмтрэх:

Хүүхдийн зовхи, зовхины ирмэг, нүдний хөдөлгөөн, нулимсны нүх, нүдний салстыг ажиглаж эрүүл харагдаж байна уу? Зовхи улайж, хавдсан байна уу? Нүдний гэрлийн рефлекс хоёр нүдэнд ижил байна уу? Нүд хялар харж байна уу? Нулимс гоожиж, цийлэгнэж байна уу? Нүд нуухтаж байна уу? Нүдний улайлт байна уу?

Нүдийг зүүн талаас эсвэл эгц өмнөөс тусгасан гэрлийн тусламжтайгаар үзнэ. Үүнд:

- Ухархайн ирмэг тэмтрэх /барзгар, тэгш, гөлгөр, зузаарсан/
- Зовхины байрлал, хөдөлгөөн, улайлт, цус харвалт, хаван, нэвчдэс, ирмэг тэгш эсэх зузаарсан, сормуусны ёроолоор тав тогтсон, шарх, уйланхайтай эсэх, зовхины завсар /өргөн, нарийн, бүрэн хаагдсан.
- Нүдээ анивчсан? Хэвийн үед 2 нүд ижил 15 удаа/минут нүд цавчина.

**Хялар:** Нүдний эвэрлэгийн гэрлийн рефлекс хоёр нүдэнд ижил байна.

/нүд гадагш, дотогш, дээш, доош хазайсан. Нүдний хөдөлгөөн чөлөөтэй ба чөлөөтэй бус/

**Зовхины гаж хөгжил:** Зовхины ирмэг доош буусан, гадагш эргэсэн, сэтэрхий үүссэн байна.

Хэвийн үед зовхи нойтон, ирмэг ягаан, сормуус богино, жигд байрласан, гадагшаа эргэсэн, доод зовхины ирмэг солонгон бүрхүүлд хүрсэн, дээд зовхины ирмэг солонгон бүрхүүлийг 2 мм орчим тагласан байна

Шаардлагатай бол хүүхдийн харааг дараах байлаар шалгаж болно:

3х3 м хэмжээтэй хар бараан даавуун дээр 1 м-ийн хуваарьтай

хэмжигчийг, мөн хүүхдийн суух байрыг голд нь тэмдэглэсэн дэвсгэр бэлдэнэ.

Өрөө тасалгааг жигд сайн гэрэлтүүлнэ. Улаан, ногоон, хөх зэргийн тод өнгөтэй янз бүрийн геометрийн дүрстэй, 5 мм хэмжээтэй мод, хуванцар зэргээр хийсэн зүйлсийг янз бүрийн зайнд тавьж, хэдэн метрийн зайнаас хүүхэд хараад, авах гэж оролдож байгаагаар нь харааг тодорхойлно.

### 6.6.6 Чих хамар хоолойн үзлэг

#### Асуух:

- Хоолой өвддөг үү? Хамар битүүрдэг үү? Битүүрдэг бол улирлын хамаарал байна уу?
- Чихнээс булаг гардаг уу? Одоо гарч байна уу? Хэрэв гардаг бол жилдээ хэд дахидаг вэ? Хамгийн сүүлд хэзээ гарсан бэ? Сонсгол хэвийн үү?
- Дуу сөөдөг үү? Сөөдөг бол эмнэлэгт үзүүлж онош тодруулж байсан уу?
- Энгийн яриаг сонсохгүй юу? Шивнээ яриаг сонсохгүй юу? Хашгирч ярихад сонсохгүй юу?

#### Ам, хоолой, залгиурыг харах (хамгийн сүүлд үзнэ):

Амны хөндийн салст, шүд, буйл эрүүл байна уу? Залгиурын ар ханын лимфоид эдэн хөхлөг томорсон, улайсан, олширсон эсэх, гүйлсэн булчирхайн томорсон, үрэвсэлтэй эсэхийг харна.

*Жич:* 7 хүртэлх насны хүүхдийн гүйлсэн булчирхай том, аажимдаа багасах тул эмгэг гэж үнэлэхгүй. Харин гүйлсэн булчирхай өнгөртэй байвал эмгэг гэж үнэлнэ.

#### Хамрын өмнөд дуран хийж үзэх:

Хамрын үзүүрийг хуруугаар ээтийлгэн сөхөж, үүдэвчийг харна. Эмгэгийн шинжтэй тохиолдолд хамрын толь ашиглан өмнөд тольдолт хийж дараах шинжүүдийг харна. Үүнд:

- Хамрын таславч муруйсан эсэх
- Самалдгууд хөөнгө, том, хөхөлбөр
- Хамрын хөндийд ялгадастай, полиптой, хавдар төст үүсгэвэртэй эсэх
- Дайвар хөндийн хурц, архаг үрэвслийг илтгэх хэсэг газрын шинжүүдийг харна.

#### Чих дурандах:

- Хэрэв хүүхдийн чихнээс булаг гарч байвал лүүз (отоскопи) хийх шаардлагагүй.
- Хэрэв чихнээс булаг гараагүй боловч өмнө нь булаг гарч байсан, дахидаг гэсэн өгүүлэмжтэй бол лүүзээр үзнэ. Гадна чихний дэлбээг 3 нас хүртэл доош нь арагш, 3-аас дээш

насанд дээш нь, арагш нь татаж сувгийг тэгшлээд гадна чихний сувгийг харж эмгэгийн сэжигтэй тохиолдолд дурандаж дараах шинжүүдийг харна.

Сувагт идээт ялгадастай

- Ялгадасгүй боловч хэнгэргэн хальс цоорсон
- Хэнгэргэн хальс цүлхийсэн, дотогш татагдан наалдсан

### **Чихний дуранг хэрхэн ашиглах вэ?**

- Лүүз ариун, чихний дурангийн гэрэл тод байгаа эсэхийг шалгана. Хүүхдэд зовиур үүсгэхээргүй хамгийн том лүүзийг сонгоно.
- Лүүз ариун, чихний дурангийн гэрэл тод эсэхийг шалгаж, тохирох лүүзийг сонгоно.
- Хүүхдийг эхийн өвөр дээр хажуу тийш харуулан суулгаж, 2 хөлийг нь эхийн хөлний хооронд хавчуулан, гарыг хөдөлгөөнгүйгээр эхийн гараар даруулж, нөгөө гараар толгойг түшнэ.
- Чихний дуранг нэг гартаа үзэг мэт бариад, үзлэгийн явцад хүүхдийг огцом хөдлөн чихээ гэмтээхээс болгоомжлон гараараа хүүхдийн толгойг тулна. Чихний сувгийг тэгш шулуун болгохын тулд дэлбээг нөгөө гараараа зөөлөн татна.
- Үзлэгийг эрүүл чихнээс эхэлнэ.
- Эхлээд сувгийн амсар хэсэгт гэрэл тусгаж сувгийнхаа наад хэсгийг харна.
- Чихний дурангаар цаашид харангаа лүүзээ суваг руу зөөлөн хийнэ. Сувгийн гүн хэсэг нь маш мэдрэг тул хэт гүн хийж болохгүй, ханыг гэмтээж болзошгүй.
- Гадна чихний сувгийг шинжил. Хэвийн байна уу? Хэнгэргэн хальсыг харж чадаж байна уу?
- Хэвийн хэнгэргэн хальс нь сувд шиг өнгөтэй харагддаг.

### **Сонсгол шалгах:**

- 18 сартай хүүхэд нэрээр нь дуудахад тэр зүгт харж, энгийн даалгаврыг ойлгон ойр зуурын үйлдэл хийнэ.
- Тухайлбал, “Хамартаа гараа хүргэ”, “Амаа заа”, “Гараа гэдсэн дээрээ тавь” гэхэд үйлдлийг гүйцэтгэнэ. Хэрэв хүүхэд энгийн ярианд хариулахгүй бол чанга дуугаар давтаж хэлнэ. Зөв хариулахгүй бол хашгирч давтаж асууна.

## **6.6.7 Амьсгалын тогтолцоо**

### **Асуух:**

Ханиалгаж байгаа эсэх, ханиаж байвал 14 хоногоос дээш хугацаанд ханиалгаж байна уу?, ханиахад цэр гардаг уу, цэрний хэмжээ, өнгө зэргийг асууна. Хүүхдэд багтрааны /астма/ хөдлөл ганц удаа тохиолдож байсан ч астматай гэж үнэлнэ. Мөн хурхирдаг эсэхийг асууна.



**Ажиглах ба чагнах:**

**Хүүхдийн амьсгал тоолох:** Бага насны хүүхдэд хэвлийн хөдөлгөөнийг харж, хүүхэд уйлаагүй, тайван байгаа үед заавал НЭГ МИНУТЫН турш тоолж үзлэгийн маягтад тэмдэглэнэ (15 секундэд тоолж 4-өөр, эсвэл 30 секундэд тоолж 2-оор үржүүлж БОЛОХГҮЙ).

*Хүснэгт 1. Хүүхдийн амьсгалын хэвийн тоо*

Нас	Амьсгалын тоо
Нярай /2 сар хүртэл/	30-60
Хөхүүл насны хүүхэд /1 нас хүртэл/	20-50
Бага насны хүүхэд /1-5 нас хүртэл/	15-40
Өсвөр үе	10-20

**Жич:** Хэрэв 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын тоо олширсон, цээж хонхолзох шинж илэрч байвал ХӨЦМ-ийн дагуу арга хэмжээг авна. Хүүхэд хамраар амьсгалж байна уу, амаар амьсгалж байна уу гэж ажиглана.

Цээжийг чагнаж амьсгалын хэм, амьсгал авалтын гүнзгий байдал буюу харьцаа, шуугиан, хяхтнаа, хэржигнүүр байна уу? Амьсгалд туслах булчин оролцох, хамрын угалз сарталзах, хөхрөлт зэргийг үнэлнэ.

**6.6.8 Цусны эргэлтийн тогтолцоо****Асуух:**

Жингийн алдагдал, хөгжлийн хоцрогдол байгаа эсэхийг асууна. Үүнд: Нийгэмшихүйн хөгжил, хэл ярианы хөгжил, хөдөлгөөн хоцрогдолтой эсэх, хооллоход бэрхшээлтэй /хөхөх, угжаар хооллох, нэмэгдэл хоол өгөхөд/ эсэх, тоглох, идэвхтэй хөдөлгөөн хийхэд ачаалал даах чадвар бага, ядрах хандлагатай юу? Хэт цочромтгой эсвэл их уйлдаг уу? ...гэх мэт

**Ажиглах ба тэмтрэх:**

- Цээжний хэлбэрт өөрчлөлт орсон эсэх,
- Зүрхний оройн түлхэлт илт харагдаж байгаа эсэх,
- Судасны лугшилтыг хэм, хүчдэл дүүрэлтийг үнэлнэ.

Бага насны хүүхдэд, шууны судсыг нь тэмтрэхэд хэцүү байвал бугалганы судас тэмтэрч болно.

**Хүүхдийн зүрхний цохилт, судасны лугшилтыг тоолох:** Бага насны хүүхдийн зүрхний орой дээр чагнуураа байрлуулж, зүрхний оройн цохилтыг НЭГ МИНУТЫН турш тоолно.

Монгол эрүүл хүүхдийн 1 минутад цохилох судасны лугшилтын тоо (ЛТ):

$$1 \text{ нас хүртэл хүүхдийн ЛТ}=140 - \text{насалсан сар}$$

$$1-18 \text{ настай хүүхдэд ЛТ}=128 - 3,7 \times (\text{нас} - 1)$$

*Хүснэгт 2. Нярай ба хүүхдийн зүрхний цохилтын дундаж тоо*

Нас	Дундаж тоо	Стандарт хазайлт
Төрөхөд	140	90-190
Эхний 6 сар	130	80-180
6-12 сар	115	75-155
1-2 нас	110	70-150
2-6 нас	103	68-138
6-10 нас	95	35-125
10-14 нас	85	55-115

*Монгол хүүхдийн артерийн цусны их даралтын дунджийг тодорхойлох томъёо:*

$$1 \text{ нас хүртэлх хүүхдийн артерийн даралт АД}= 70+2 \times (\text{сар} - 1)$$

$$1 \text{ наснаас дээш хүүхдийн артерийн даралт АД}= 92+1,7 \times (\text{нас} - 1)$$

### Чагнах:

Зүрхний цохилтыг чагнуураар чагнаж, хэм алдагдал, шуугиан байгаа эсэхийг тодруулна. Хэрэв хэм алдагдалтай байвал дахин тоолно.

## 6.6.9 Хоол боловсруулах эрхтэн тогтолцоо

### Асуух:

Хоолны дуршил, хоолны шингэц, хоол шингэхгүй, бөөлжилт, суулгалт, баасны шинж, тухайлбал баас хатдаг, баахад өвддөг, баас цустай буюу хар өнгөтэй гардаг эсэх болон хошног загатнадаг эсэхийг асууж тэмдэглэнэ.

### Ажиглах ба тэмтрэх:

- Хэвлийн хэлбэр, хэмжээ,
- Хэвлийн өнгөц венийн судас тод өргөссөн эсэх,
- хэвлийн хөдөлгөөн,
- хүйс, түүний байрлал, хэлбэр, хүйсний ивэрхий зэргийг ажиглана.
- Хэвлийг тэмтрэхэд эмзэглэлтэй эсэх,
- Элэгний хэмжээ, ирмэг, бүтэц, эмзэглэл, гадаргууны байдал,
- Дэлүү тэмтрэгдэж байна уу?
- Хэвлийн хөндийд усжилттай эсэхийг тэмтэрч тэмдэглэнэ.

Хэвлий нь хэвийн үед бөөрөнхий, бага насны хүүхдэд суугаа үед цилиндр, хэвтэж байгаа үед хавтгай хэлбэртэй байх ба **хүйс хонхорхой**, төвдөө байрласан, цэвэрхэн байна.

Хүүхдийн дэлүүг баруун хажуугаар хэвтүүлж зүүн хавирганы нумаар тэмтэрч үзнэ.

Бага насны хүүхдэд хэвийн үед элэг, дэлүү хавирганы нумаас доош 1-3 см тэмтрэгдэж болно.

#### 6.6.10 Шээс ялгаруулах тогтолцоо ба гадна бэлэг эрхтэн

##### Асуух:

Хоногийн шээсний хэмжээ, тоо, өнгө? Орондоо шээдэг эсэх, шээхдээ уйлдаг эсэх, шөнө их шээдэг эсэх, шээсэнд цус гардаг, шээсэнд тунадас үүсдэг, шээс тасалддаг зэргийг тодруулж асууна.

##### Ажиглах ба тэмтрэх:

- Цавины ивэрхийтэй эсэх,
- Бөөр тэмтрэгдэж байгаа эсэх,
- Давсаг тэмтрэхэд эмзэглэлтэй эсэх,
- Хоногийн шээсний өнгө үнэр,
- Шээсний сүв харагдаж байгаа эсэхийг ажиглаж тэмтэрч үзнэ.

##### **Гадна бэлэг эрхтэн:**

##### Ажиглах ба тэмтрэх:

Тээрхийн арьс чөлөөтэй эргэдэг эсэх, 2 талын, баруун талын, зүүн талын төмсөг хуухнагт буусан эсэхийг ажиглана.

**Фимоз:** 3 нас хүртэл 2 янз байдаг ба ихэвчлэн физиологийн буюу хэвийн байна.

Хэрэв шээсний сүв харагдахгүй, шээхэд шээсний сүв шар шиг бөмбийдөг ойр ойрхон шээдэг бол анхаарна. Мэргэжлийн эмчид үзүүлэхийг зөвлөнө.

3-аас дээш насны хүүхдэд фимоз байвал мэргэжлийн эмчид үзүүлэхийг зөвлөнө.

**Крипторхизм:** Төмсөг хуухнагт буугаагүй тохиолдолд 1 нас 6 сартайгаас хойш мэргэжлийн эмчид үзүүлэхийг зөвлөнө.

#### 6.6.11 Төв мэдрэлийн тогтолцоо

##### Асуух:

Татдаг эсэх, нярай үедээ тархины хүчилтөрөгчийн дутагдалтай байсан эсэх, саажилт байсан эсэхийг асууж тодруулна.

##### Ажиглах ба тэмтрэх:

- Хүүхдийн нүүр, гар хөлөнд саа, саажилт байна уу?
- Хүний нүд рүү харахгүй, эсвэл царайны хувиралгүй, эсвэл хэт цочромтгой эсэх,
- Эмгэг рефлексүүд илэрч байгаа эсэхийг шалгана. Дагзны булчингийн хөшингийг шалгана. Ингэхдээ хүүхдийн сонирхлыг татах тоглоом харуулж, хүйс орчимд барихад толгойгоо өлийлгөж хүүхдийн эрүү цээжиндээ хүрч байвал хөшингө байхгүй гэж үзнэ.

### 6.6.12 Илт харагдах болон үзлэгээр илэрсэн гаж хөгжил

#### Ажиглах:

Чихний дэлбэнгүй, чихний гадна суваггүй, чихний дэлбэнд сэтэрхийтэй, эсвэл чих орчим сүвтэй байна уу?

Хүүхэд гар, хөл бүрэн эсэх, дутуу бол энэ нь төрөлхийнх үү, эсвэл олдмол (Жишээ нь: гэмтлээс) уу? Нүдний (төрөлхийнх үү, олдмол) алимгүй байна уу? зэргээр хүүхдийн бүх биеийг (гар, хөлийн хурууны тоо гэх мэт) ерөнхийд нь ажиглаж, өөрчлөлтийг дэлгэрэнгүй бичнэ.

Тухайлбал: Хэвийн чихний дэлбэн ижил хэмжээтэй, ерөнхий хэлбэр адил, байрлал нүдний өнцгийн дагуу хэвтээ шугамаас бага зэрэг дээш цухуйсан, босоо шугамаар  $10^0$ -ын өнцөг үүсгэж байрлана.

### 6.6.13 Амны хөндий:

Тав хүртэлх насны хүүхдэд амны хөндийн үзлэгийг хамгийн сүүлд хийнэ. 18 сартай хүүхэд 14 орчим шүдтэй байа.

#### Асуух:

Хэдэн сартайд эхний шүд ургасан гэж асууна. Шүд нь өвддөг үү? Амны хөндийд хагалгаа хийлгэж байсан уу? Шүд нь ургаагүй байна уу?

#### Ажиглах ба тэмтрэх:

- Эхлээд амыг хаалттай ажиглаж, дараа нь ангайлгаж хэлний өмнөд  $2/3$  хэсэгт хэл дарагчаар дарж дараах шинжүүдийг харна.
- Шүд хоорондын зай ихэссэн, шүдний цууралт, хазалт шаамий болон орсгой? Шүдэнд цагаан толбо үүссэн эсэх, шүдний ирмэг тэгш бус, цооролттой, өнгө нь хар, бор болсон эсэх,
- Одоо хэдэн шүдтэй байгаа?
- Уруул, амны хөндийн үрэвсэл, шарх байгаа эсэх, буйлны үрэвсэлтэй эсэх,
- Хэлэнд зангилаа үүссэн, хуурай, хөхлөггүй эсвэл хөхлөгүүд тодорсон, хэл тэгш хэмгүй, аль нэг тар руугаа мурийсан, голын зураасгүй эсэх, Хэл чичирхийлж байгаа эсэх,
- Хатуу ба зөөлөн тагнай 2 талдаа тэгш хэмтэй, ирмэг тэгш байна уу?
- Уруул, тагнайн сэтэрхийтэй эсэх, сэтэрхийтэй бол мэс засал хийлгэсэн эсэх?
- Уруул ба хэлний хөвч богино эсэхийг харж ажиглана.

**Жич:** Уруулын сэтэрхийтэй хүүхдийг 3-4 сартайд, биеийн жин 6 кг хүрсэн, үед, тагнайн сэтэрхийтэй хүүхдэд 1 нас 6 сартайд, биеийн жин 10 кг хүрсэн үед мэс заслын эмчилгээ хийлгэхийг эх эцэгт зөвлөнө.

Хэвийн үед дээд эрүүний шүд доод эрүүний шүдэнд хүрсэн, ба дээд үүдэн шүд доод үүдэн шүднээс бага зэрэг гадуур нь байна. Уруул, жавьж нойтон, гөлгөр, шархлаагүй, ягаан өнгөтэй, уруулын ирмэг тод байна. Шүдний гадаргуу жигд, гөлгөр, сувдан өнгөтэй.

Хэл ягаан, нойтон, хөхлөгүүд тод, жигд, хэлний голын зураас харагдана.

**Уруулын хөвч:** Буйлны доод ирмэгээс шилжих нугалаа буюу буйлны хэсгийн салст үүдэвчний хэсэгт шилжиж буй хэсэг хүртэлх зайн 1/2-ээс дээш хэлний хөвч бэхлэгдсэн байвал хэвийн гэж үзнэ. Түүнээс доош бэхлэгдсэн хоншоорын төвийн үүдэн шүднүүд хоорондоо зайтай бол дээд уруулын хөвч богино гэж үзнэ.

Хэлний хөвч хэлний үзүүр хэсгээс бэхлэгдсэн, хэлний хөдөлгөөн саадтай бол хэлний хөвч богино гэж үзнэ. Энэ үед хэл яриа өөрчлөгдөж, доод үүдэн шүдний байрлал хэвийн бус байдаг. *Жич: Сүүн шүдэнд цоорлоос хамгаалж түрхсэн хар түрхэцийг ломботой гэж үнэлнэ.*

Дараах шүдний зурагт сүүн шүдний ургах хугацаа, солигдох хугацааг хажууд нь бичсэн ба үсгээр тэмдэглэдэг. Мөн байнгын шүдний ургах хугацааг бичсэн.

Цоорсон болон эмчилгээ хийгдээгүй шүдийг зурагт (X) гэж тэмдэглэх ба эмчилгээ шаардлагатай шүдний тоог бичнэ.

	Доод эрүү	Ургалт	Солигдох
	2 дахь бага араа	23-31 сар	10-12 нас
	Эхний бага араа	14-18 сар	9-11 нас
	Соёо	17-23 сар	9-12 нас
	Доод үүдэн хажуу	10-16 сар	7-8 нас
	Доод үүдэн	6-10 сар	6-7 нас

Сүүн шүдний зураг			
	Дээд эрүү	Ургалт	Солигдох
	Дээд үүдэн	8-12 сар	6-7 нас
	Дээд үүдэн хажуу	9-13 сар	7-8 нас
	Соёо	16-22 сар	10-12 нас
	Эхний бага араа	13-19 сар	9-11 нас
	2 дахь бага араа	25-33 сар	10-12 нас

## 6.7 ДАРХЛААЖУУЛАЛТ

Монгол Улсын “Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлол”-ын дагуу, хүүхэд төрөнгүүт 24 цагийн дотор сүрьеэ, халдварт саа, гепатитын В вирусын эсрэг дархлаажуулах ба 2 сартайгаас эхлэн 3 сар, 4 сар, 5 сартайд тус бүр халдварт саагийн эсрэг болон Тавт вакцин буюу сахуу, татран, хөхүүл ханиад, хемофлюс инфлюенза, гепатитын В вирусын эсрэг хавсарсан вакцин болон пневмококкийн шалтгаантай хатгалгааны эсрэг вакцинуудаар дархлаажуулдаг. Харин 9 сартайд УГУ буюу улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилгуудыг хийдэг. 18 сартайд эдгээр дархлаажуулалтыг хийлгэсэн байх ба хамрагдаагүй хүүхдэд шалтгааныг асууж зөвлөгөө өгнө.

Хүснэгт 3. Дархлаажуулалтад хамрагдсан талаарх тэмдэглэл

Товлол	Вакцинууд	Хийсэн огноо/сери
Төрснөөс хойш 24 цагийн дотор	БЦЖ (Сүрьеэгийн эсрэг вакцин) (BCG)	
	Халдварт саагийн эсрэг вакцин (Polio)	
	В Гепатитын эсрэг вакцин (Hep B)	
2-4 сартайд	Халдварт саагийн эсрэг вакцин (Polio)	
	Тавт вакцин (Сахуу, хөхүүл ханиад, татран, +В Гепатит, хемофилус инфлюенза В) (Penta)	
	Пиевмококкийн эсрэг вакцин (PCV)	
5 сартайд	Халдварт саагийн эсрэг вакцин (Polio)	
9 сартайд	УГУ вакцин (Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг) (MMR)	
	Пиевмококкийн эсрэг вакцин (PCV)	
1 нас 2 (24 сар) сартайд	А Гепатитын эсрэг вакцин (Hep A)	
Бусад		

## 6.8 ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүүхдийн хөгжлийг 1. Мэдрэхүй, хөдөлгөөн 2. Танин мэдэхүй, үйлдэх 3. Хэл яриа, харилцаа 4. Бие дааж хийх үйлдэл, эрүүл мэнд 5. Нийгэмшихүйн айд хуваан насанд нь тохирох асуумжаар үнэлж болно. 18 сартай хүүхдийн үзлэгийн маягтад байгаа асуумжийн дагуу хөгжлийг үнэлэхдээ эрүүл мэндийн ажилтан эцэг эхээс нь асуухын зэрэгцээ өөрөө ажиглаж үзүүлэлт бүрийг бөглөнө.

Түүнчлэн “Тусгай тэмдэглэл: Асран хамгаалагчийн санал болон нэмэлт тэмдэглэл” хэсэгт асран хамгаалагчийн асуулт, санал зэрэг зөвлөгөөний агуулгыг тэмдэглэнэ.

Хүснэгт 4. 18 сартай хүүхдийн хөгжлийг үнэлэх асуумж

	Асуумж	Хөгжлийн ай
1	Хүүхэд өөрөө сайн явж чадаж байна уу? (Хэдийд хөлд орсон)	Хөдөлгөөн (том булчин)
2	Хүүхэд ээж, аав надаа гэх мэт утгатай үг хэлж байна уу?	Хэл яриа
3	Аяганаас өөрөө ууж чадаж байна уу?	Хөдөлгөөн (жижиг булчин) Танин мэдэхүй, үйлдэх Бие дааж хийх үйлдэл, эрүүл мэнд
4	Хүүхэд цагаар хооллодог уу?	Бие дааж хийх үйлдэл, эрүүл мэнд
5	Хүүхэд угжаар уусаар байна уу? (Шүд цоорохоос сэргийлэх зорилгоор угжаар уухыг зогсоох хэрэгтэй)	Бие дааж хийх үйлдэл, эрүүл мэнд
6	Хүүхдийн нүд нь ер бусын хөдлөх эсвэл гэрэлд хэт мэдрэмтгий байдаг уу?	Мэдрэхүй (Хараа)
7	Хүний нүд рүү эгцэлж харж чадаж байна уу?	Нийгэмшихүй
8	Хүүхдийг араас нь нэрээр дуудахад эргэж хардаг уу?	Мэдрэхүй (Сонгол) Хэл яриа Нийгэмшихүй
9	Хүүхдэд шүдээ угаахыг зааж өгөхөд дууриаж угааж чаддаг уу?	Танин мэдэхүй, үйлдэх Нийгэмшихүй
10	Таны хүүхэд юу хийх, оролдох дуртай вэ?	Танин мэдэхүй, үйлдэх Хөдөлгөөн Нийгэмшихүй
11	Хүүхдээс мэддэг юмыг нь асуухад хуруугаараа зааж чадаж байна уу?	Танин мэдэхүй (юмыг оноож заах), үйлдэх Хэл яриа Нийгэмшихүй
12	Өөрийн биеийн эрхтнүүдийг мэддэг үү? Тухайлбал амаа ангай, хэлээ гарга гэх мэт	Танин мэдэхүй, үйлдэх Хэл яриа
13	Хүүхэдтэй хамт байхдаа тэдэнтэй хамтдаа тоглодог уу?	Нийгэмшихүй
14	Танил хүмүүстэйгээ ярилцах дуртай юу?	Нийгэмшихүй
15	Тэврэхэд хариуд нь бас тэвэрнэ	Нийгэмшихүй
16	Өөртэй нь тоглоход инээнэ, ход ход инээнэ.	Нийгэмшихүй

Эдгээр асуумжуудаар хэрхэн үнэлж, эцэг эхэд зөвлөгөө өгөх талаар 2 дугаар бүлэгт тодорхой тайлбарласан болно.

## 6.9 ОНОШ/ ҮНЭЛГЭЭ, ЭХ ХҮҮХДЭД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

Тухайн хүүхдэд үзлэгээр илэрсэн бүх хэвийн бус өөрчлөлтийг бичнэ.

**Жишээ нь:** 6.6- д заасан дагуу хэвийн бус гэж тэмдэглэсэн, чихнээс булаг 7 хоног гарсан бол Дунд чихний цочмог үрэвсэл онош тавина. Хөгжлийн үнэлгээгээр ээж аав гэх мэт үг хэлж чадаж байна уу гэсэн асуултад ҮГҮЙ гэж хариулсан бол Хэл ярианы хоцрогдолтой гэж тэмдэглэнэ.

### Онош/үнэлгээ ба эх, хүүхдэд өгсөн зөвлөмж

#### 1. Эрүүл мэндийн онош/үнэлгээ

*Дунд чихний цочмог үрэвсэл*

Зөвлөмж: 5 өдрийн турш антибиотик уухыг зөвлөж бичиж өгнө. Чихээсээр чихийг хуурайшуулна.

#### 2. Хөгжлийн онош/үнэлгээ

*Хэл ярианы хоцрогдол*

Зөвлөмж: Хүүхэдтэйгээ өдөр бүр 30-аас доошгүй минут ном уншиж ярилцаж байх хүүхдээс энэ юу вэ гэх мэт асуулт асууж хариулуулахыг хичээх

#### 3. Хоол тэжээлийн талаар онош/үнэлгээ

Зөвлөмж:

Явцын хяналт, ажиглалт:

*5 хоногийн дараа чихийг эргэж үзүүлэх,*

*1 сарын дараа хэл ярианы талаар эргэж үзүүлэх*

Төрөлжсөн мэргэжлийн зөвлөгөө \_\_\_\_\_

Эрүүл мэндийн дэлгэрэнгүй шинжилгээ \_\_\_\_\_

Илгээсэн байгууллага, газар \_\_\_\_\_

Үзлэг хийсэн байгууллага: \_\_\_\_\_

Эмчийн нэр: \_\_\_\_\_ /гарын үсэг/

Тухайн хүүхдэд яаралтай эмнэлгийн тусламж шаардлагатай бол холбогдох зөвлөмжийг “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”, “ХӨЦМ”, “Эрэмбэлэн ангилах яаралтай тусламж”, “Хүүхдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний өврийн дэвтэр” ба “Хүүхдийн өвчин” сурах бичигт заагдсаны дагуу тохирох зөвлөгөө, эмчилгээг өгнө.



# 2

## ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ХӨГЖЛИЙГ ҮНЭЛЭХ АРГА БОЛОН ГЭР БҮЛД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ

Энэ бүлэгт 18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн маягт дахь нийт 16 хөгжлийн үзүүлэлт тус бүрийн зорилго, хөгжлийг шалгах арга болон эцэг эхэд өгөх зөвлөгөөний талаар дэлгэрэнгүй тайлбарлав.

### 1. Өөрөө алхаж чадаж байгаа юу?

Зорилго	Том булчингийн хөдөлгөөний хөгжлийг шалгах
Шалгах арга	Өрөөнд, ямар нэг саадгүй шалан дээр хэрхэн алхахыг харна. 18 сартай ихэнх хүүхэд, тэгшхэн шалан дээр 2-3 метрээс илүү зайд өөрөө алхаж сурсан байдаг. Мөн өөрөө алхаж суртал “Мөлхөх (9 сар орчимд) → Юм түшиж босох, дамжиж явах, гараа алдалж зогсох (12 сар орчимд) → 2-3 алхах (13 сар орчимд)” гэсэн үе шатуудыг дамждаг.
Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"><li>- Хүүхэд 18 сар хүрсэн ч зөвхөн мөлхөх, эсвэл гараараа юм түшиж, зогсохоос хэтрэхгүй байвал эмчид хандаж нарийвчилсан үзлэг хийлгэх шаардлагатай.</li><li>- Гэхдээ зарим хүүхэд хэт хаширлан шалан дээр саад байвал мөлхөх, эсвэл дамжиж явах нь найдвартай бөгөөд хурдан санагддаг тул дөнгөж 2-3 алхаад больчихдог. Тиймээс гэр доторх орчин болон гадаа тоглох байдал зэргийг эцэг эхээс асууж тодруулах нь чухал.</li><li>- Мөн бага насны хүүхдийн хөдөлгөөний хөгжил нь “Биеэр хөдөлгөөн хийж суралцах”-тай нягт холбоотой. Өдөр тутамд хүүхдийн сонирхол татах зүйлийг аль болох олон болгох, хүүхэд өөрөө хөдөлгөөн хийж, ямар нэг зүйл эрж хайх үйлдэл хийлгэж байх нь хөдөлгөөний хөгжилд нь үлэмж тустай.</li><li>- “18 сартай болчихоод хөлд ороогүй юм уу” гэх зэргээр хөдөлгөөний хөгжилд нь хоцрогдол байгааг шууд хэлж, эцэг эхийг нь сэтгэлээр унагахгүй байхад анхаарах хэрэгтэй. “Хөлд оруулах” гэж яаралгүйгээр, мөлхдөг, эсвэл дамждаг байх нь чухал биш, гол нь гэртээ осол аюулгүйгээр ямар нэг зүйл эрж хайх үйлдэл хийх боломжтой орчин бий болгож өгөх, биеийн хөдөлгөөн шаардагдах тоглоомоор эцэг эх нь хамтдаа тоглож байхыг зөвлөх нь зүйтэй. Хүүхэд биеэрээ хөдлөх боломжтой тоглоомоор тоглуулвал, хөлд ороход нь тустай тэнцвэрээ олох чадвар, булчингийн хөгжил сайжирч “Өөрөө алхах” дуртай болно.</li></ul>

## 2. Утгатай үг, жишээ нь “Ээж”, “Аав” гэж хэлдэг үү?

Зорилго	Хэл ярианы хөгжлийг шалгах
Шалгах арга	<p>Эцэг эхээс нь асууна. Хэлж чаддаг үгийг нь нэг бүрчлэн асууж, тодорхой нэг зүйлийн талаар 2-оос дээш үг хэлж чаддаг эсэхийг тодруулна. 2-оос дээш авианаас бүтсэн, утга нь ойлгомжтой үг хэлж чадаж байвал, дуудлага тааруу байхад асуудалгүй. Харин хүний хэлснийг зүгээр давтаж хэлэхийг (Эхолалия буюу тоть хариулт) тооцохгүй.</p>
Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- 18 сартай ихэнх хүүхэд 2-оос олон үг хэлдэг (Үгээр илэрхийлэх). Үүний өмнөх үе шат буюу 12 сар хүрэхээс өмнө өөрөө хэлж чадахгүй ч, хүний хэлснийг сонсоод ойлгодог үг (Үг ойлгох) олон болж ирнэ. Өөрөө хэлж чадахгүй ч, хүсэж байгаа зүйл, сэтгэл санааны байдлаа хуруугаар заах, эсвэл биеийн хөдөлгөөн, нүүрний хувирлаар хэлэх гэж оролддог.</li> <li>- Хүүхэд бүрийн үгээр өөрийгөө илэрхийлэх байдал харилцан адилгүй байдаг тул 18 сартай хүрсэн ч 2-оос дээш үгээр илэрхийлж чадахгүй байвал, сонсоод ойлгодог үг хэр олон байгаа, харьцаж буй хүндээ биеийн хөдөлгөөнөөр болон хуруугаараа зааж сэтгэл санаагаа дамжуулж чадаж байгаа эсэхийг эрүүл мэндийн үзлэгээр шалгаж, эцэг эхээс нь асуух шаардлагатай.</li> <li>- Хүний хэлснийг хэр зэрэг ойлгож байгааг нь шалгахын тулд, өдөр тутамд хүүхдийн сайн мэддэг зүйл, хүмүүсийн талаар “... аль нь вэ?, ... хаана байна вэ?” (Жишээ: Аяга нь аль вэ? Ээж нь хаана байна? г.м) гэж асуугаад, тухайн үгэнд тохирох юмсыг болон хүн рүү харах эсэх, гараараа заах эсэхийг нь ажиглана. Мөн 11, 12 дахь хөгжлийн үзүүлэлтээр бусдын хэлснийг ойлгох чадварыг нь тодорхойлох боломжтой.</li> <li>- Ийм ажиглалтаас, хүүхэд үгээр илэрхийлэх тал дээр хоцрогдолтой байсан ч, эцэг эхийнхээ хэлсэн үгэнд хариу үйлдэл үзүүлэн ямар нэг үйлдэл хөдөлгөөн хийх, биеийн хөдөлгөөн, дуу авиагаар эцэг эхдээ сэтгэл санаа, хүсэж буй зүйлээ ойлгуулж байвал, заавал үгээр хэлүүлэх гэж шахахгүйгээр, аль болох хүүхдэд ойлгомжтой, хялбар үгээр ярьж хэлэх, сэтгэл санааг нь зөв ойлгож өмнөөс нь ярих байдлаар харьцаж байвал, хүүхдийн өөрөө хэлж чадах үг нь явцын дунд нэмэгдэнэ.</li> </ul>

Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Сонсголыг шалгахдаа, 8-д дурдсан бусадтай харилцах эрмэлзэлийг 7, 14, 15, 16 дахь хөгжлийн үзүүлэлттэй жиших шаардлагатай. Сонсголын асуудалтай байвал, хэл ярианы чадвар хоцрогдох тул мэргэжлийн эмчид хандан, сонсгол шалгах үзлэг шинжилгээнд хамрагдах шаардлагатайг нь хэлж өгөх хэрэгтэй.</li> <li>- Бусадтай харилцах эрмэлзэлд асуудал байвал, хүүхдийнхээ дуртай зүйлийг нь ашиглан, бусадтай харилцах нь ямар сонирхолтой болохыг ойлгуулах байдлаар ажиллах арга зүйг эцэг эхэд нь зөвлөнө. Шаардлагатай гэж үзвэл, эрүүл мэндийн үзлэгийн дараах нэмэлт үйлчилгээ, тоглоомын аргаар эх хүүхдийг хөгжүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар танилцуулж, хөгжлийн хоцрогдолд (Аутизмын хүрээний эмгэг г.м) хийх ажиглалтаа үргэлжлүүлэх нь зүйтэй. Мөн шүлс гоожимтгой, байнга ам нь ангайж явдаг, эрүү амны хөдөлгөөн муутай, зөвхөн эгшиг авиа хэлдэг хүүхэд байвал, хооллолтынх нь (Шингэн юм уух, хатуу зүйл идэхдээ хэвийн биш байна уу, зөвхөн дуртай зүйлээ идэх сонирхолтой юу, хоолондоо юу ашигладаг вэ, хоолоо хэрхэн бэлтгэдэг вэ г.м) талаар асууж, хооллолтын зөвлөгөө өгөх, амны хөндийн нарийн үзлэг хийх шаардлага ч гарч болно.</li> </ul>
----------	--

### 3. Аяганаас өөрөө ууж чаддаг уу?

Зорилго	<p>Танин мэдэхүй ба жижиг булчингийн хөгжил, бие даах: хүүхэд хоолны хэрэгслийн зориулалтыг мэдэж байгаа эсэх, хоолны хэрэгсэл ашиглах дуртай эсэх, хоолны хэрэгсэл ашиглах чадвар, өөрөө хооллож сурч байгаа эсэх, эцэг эхийнх нь хооллолтын талаарх мэдлэг ойлголт зэргийг тодруулах.</p>
Шалгах арга	<p>Гэртээ хоолоо яаж иддэг талаар эцэг эхээс нь асууна. Эрүүл мэндийн үзлэгээр ажиглах боломжтой тохиолдолд, тоглоомон аяга таваг, хүүхдэд хоолны хэрэгсэл өгөөд хэрхэн ашиглахыг харна. Тоглоомон шилэн аяга, халбага огт сонирхохгүй, эсвэл зүгээр долоох, өнхрүүлэх, ямар нэг зүйл цохих, дотор нь ямар нэг юм хийж авах зэргээр тоглож байвал зориулалтыг нь сайн мэдэхгүй байна гэж гэсэн үг. Эцэг эхээс нь асуухдаа, хүүхэд гэртээ аяга, халбагаар ууж иддэг эсэх, өөрөө барихыг хүсдэг эсэх, аягаа сайн барьж чадахгүй асгаж цутгавал эцэг эх нь яаж тусалдаг зэргийг асууна.</p>

Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Аяганы зориулалтыг мэдэхгүй байвал өдөр тутамд огт хэрэглэдэггүй, эсвэл оюуны хөгжлийн хоцрогдолтой байх магадлалтай.</li> <li>- 18 сартай хүүхэд нэмэгдэл хоолонд бүрэн орсон байх ба гэртээ хамт хооллохдоо аяга, халбага зэрэг хоолны хэрэгслийг ашиглаж сурсан байдаг. 1 настай хүүхэд зөвхөн хүний өгснийг иддэг бол, 18 сар хүрээд “Өөрөө иддэг, эсвэл идэх гэж оролдох” зэргээр бие даан хооллож эхэлдэг. Гол нь хүүхдийн хүсэл чухал бөгөөд өөрөө сайн идэж чадахгүй байсан ч, аль болох аяга, халбага хэрэглэж сургах, асгасан ч загнаж аашлалгүйгээр, гараас нь барьж туслах зэргээр хоолыг нь илүү сонирхолтой идүүлэхийг эцэг эхэд нь зөвлөнө.</li> <li>- “Өөрөө идэх” дургүй хүүхдэд хоолоо аль болох гараараараа барьж идэх боломжийг олгон, аажмаар дасгахын чухлыг эцэг эхэд нь хэлж өгөх хэрэгтэй. Аяга ашиглах чадварын тухайд, аягаа өрөөсөн, эсвэл 2 гараараа барьж ам руугаа ойртуулах, бага зэрэг хазайлгах, уух юмаа амандаа балгах, залгих зэрэг дараалсан нарийн үйлдлүүдийг хийх шаардлагатай болно. Аяга хэрэглэх аргыг заах, уух юмаа амархан асгачихдаг хүүхдэд соруултай аягаар (Тагтай болон соруултай аяга) уулгаж эхлэх нь зүйтэй.</li> </ul>
----------	---

#### 4. Угжаар хооллодог уу? (Шүд цооролтоос сэргийлэхийн тулд угжаар хооллохыг зогсоох шаардлагатай)

Зорилго	18 сартай хүүхэд нэмэгдэл хоолонд бүрэн ордог. Хэрэв угжаар хооллодог хэвээрээ бол, хүүхэд бие даан хооллож сурахад нь саад болно. Хүүхдийн сүүн шүд 7 сар орчимтойгоос нь ургаж эхлэх бөгөөд нэг нас хүрэхэд 8 шүд ургасан байдаг. Хэтэрхий удаан хугацаанд угжаар хооллох нь дээд үүдэн шүдний эрт үеийн цоорлын шалтгаан болдог тул угжаар хооллодог үгүйг нь заавал асуух шаардлагатай. Зарим хөгжлийн хоцрогдолтой хүүхэд нэмэгдэл хоол сайн идэж чаддаггүй.
Шалгах арга	Эцэг эхээс нь асууна. Сүү, жимсний шүүс зэргийг угжаар өгдөг эсэх, угжсан болон хөхүүлсэн чигээрээ унтуулдаг эсэхийг тодруулна.
Зөвлөгөө	- Шүдны цоорол, шүдний буруу зуultaас урьдчилан сэргийлэх үүднээс угж ашиглахаа зогсоож, тагтай, эсвэл соруултай аяга, шилэн аяга ашиглаж эхлэхийг зөвлөнө.

## 5. Тогтсон цагт хооллодог уу?

Зорилго	<p>Амьдралын зөв дадалд сургах нь бага насны хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд туйлын чухал байдаг. 18 сартай хүүхдийн шөнийн нойрны хэмнэл нь тогтворжсон байх бөгөөд зөв хооллож сургаснаар амьдралын үндсэн дадал эзэмшиж эхэлдэг. Тогтсон цагт хооллодог эсэхийг тодруулснаар, хүүхэд насандаа тохирсон шим тэжээлийг авч чадаж байгаа эсэх, амьдралын хэмнэл нь алдагдаагүй эсэхийг баримжаалах боломжтой.</p>
Шалгах арга	<p>Эцэг эхээс нь асууж тодруулна. Зөвхөн хооллох цаг төдийгүй, 24 цагийн амьдралын хэмнэлийнх (Унтах, хооллох, усанд орох, тоглох зэрэг) нь талаар мэдээлэл авна. Хамт байгаа гэр бүлийнхний амьдралын хэмнэлийн талаар ч мэдээлэл авбал зүгээр. Мөн хооллохдоо, юуг ямар хэмжээгээр өгдөг, дуртай дургүй хоол байгаа эсэх, хэрхэн хоолоо иддэг зэргийг нь ч асууна. Ихэнх эцэг эхчүүд хүүхэд нь 18 сар хүрэхэд, хооллолтод нь санаа зовж, учраа олохгүй байх явдал элбэг тохиолдох учир, хооллолтын тал дээр эцэг эхчүүдийн анзаарсан, санаа зовж буй зүйлүүдийн талаар ч мэдээлэл авах нь зүйтэй.</p>
Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Амьдралын зөв хэмнэлийн тухайд, өдөр хангалттай хөдөлгөөн хийж, шөнө сайн нойр авах дадлыг хэвшүүлэх нь хүүхдийг эрүүл өсөлт бойжилт болон хөгжилд тустай бөгөөд амьдралын үндсэн дадал хэвшилд суралцах, цаашилбал цэцэрлэг, яслид орж олон хүүхэдтэй зохицоход нь хэрэгтэй гэдгийг эцэг эхчүүдэд ойлгуулах хэрэгтэй.</li> <li>- Үүний тулд, эцэг эхчүүд өөрсдийнхөө амьдралын дадал хэвшлийг өөрчилж, гэртээ тогтсон амьдралын хэмнэл бий болгохыг хичээх шаардлагатай. Тухайн айлын байдлаас шалтгаалан, эцэг эхийнх нь гэртээ харих цаг, орондоо орох цаг нь хэдийгээр их орой, эсвэл тодорхойгүй байсан ч, хүүхдийнхээ өдөр тутмын хэмнэлийг чухалчилж, өөрсдийгөө өөрчлөх ямар арга байгаа талаар эцэг эхтэй нь ярилцана.</li> </ul>

Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Амьдралын зөв хэмнэлийг бий болгохын тулд, юуны өмнө унтах, хооллох, бие засах зөв дадлыг хэвшүүлнэ. Эрт босоод өглөөний наранд ээх, тогтсон цагт өглөөний цай уух, бие зассаны дараа биеэ сайтар хөдөлгөж тоглох, өдөрт цаг хагас орчим унтах, орой эрт унтах гэсэн зөв дадлыг гэр бүлийн бүх гишүүд хамт хэвшүүлэх талаар зөвлөнө.</li> <li>- Орондоо орж өгдөггүй, шөнө олон дахин сэрэх зэргээр эрт унтаж сурахгүй байвал, унтахаас нь өмнө хоол идүүлэхгүй байх, зурагт үзэх, гар утсаар тоглуулахгүй байхад анхаарч, өрөөнийх нь гэрлийг унтраан, бүгд нэгэн зэрэг орондоо орж унтаж хэвших зэргээр сайн унтаж сурахад нь хэрэгтэй аргуудыг санал болгож болно. Хоолондоо юу иддэг, шим гэжээл дутагддаг эсэх, зөвхөн нэг төрлийн юм идэх дуртай эсэх зэргийг ч тодруулж, зөвлөгөө өгнө.</li> </ul>
----------	--

## 6. Нүд нь хэвийн бус хөдөлдөг, эсвэл гэрэлд хэт гялбадаг уу?

Зорилго	Нүдний хараа, харааны үйл ажиллагаанд нь өөрчлөлт байгаа эсэхийг шалгах.
Шалгах арга	Хүүхдийн нүд рүү эгц урдаас нь хараад хялар, нистагм буюу нүдний алим аяндаа чичиргэнэж хөдлөх шинж байгаа эсэхийг шалгана. Ингэхдээ нүднийх нь өмнө тоглоом бариад дээш доош, баруун зүүн тийш алгуур хөдөлгөж, эсвэл эргэлдүүлж харуулахад дагуулж харж байгаа эсэхийг ажиглана. Мөн ширээн дээр жижиг идэх юм тавихад гараа сунган авах гэж оролдох, эсвэл гар нь хүрэхээргүй зайд жижиг тоглоом, бөмбөг мэтийг хөдөлгөж харуулахад дагуулж харж байгаа эсэхийг нь шалгана. Зурагт болон зурагтай номыг хэт ойртож хардаг эсэх, харахдаа нүдээ онилгодог эсэх, эсвэл гэрэлд нүд нь хэт гялбадаг эсэхийг асууж шалгахад гадна ерөнхийдөө муу харж байгаа байдал ажиглагддаг эсэхийг эцэг эхээс нь асууж тодруулна.
Зөвлөгөө	- Нүдний хараа, нүдний алимны хөдөлгөөнд өөрчлөлт (нистагм) ажиглагдсан тохиолдолд, мэргэжлийн эмчид хандан үзлэг шинжилгээ хийлгэхийг зөвлөнө.

Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Харааны хөгжлийн хувьд харах талбай, зайн баримжаа болон хөдөлгөөнтэй зүйлийг харах чадвар зэрэг нь алхах, явах том булчингийн хөдөлгөөн, гар хурууны үзүүрээр юм барьж хөдөлгөх зэрэг жижиг булчингийн хөдөлгөөн, биеийн орон зайн баримжааны хөгжилд нь ихээхэн нөлөөтэй.</li> <li>- Мөн аливаа зүйлийг харж таньж мэдэх, бусдын нүүрний хувирлыг ялгаж таних зэрэг нь оюуны болон нийгэмшихүйн хөгжилд нь чухал үүрэгтэй тул хүүхдийн харааны өөрчлөлтийг анзаарч байх нь чухал. Хүүхдийн хараа, сонсголын хэвийн бус байдлыг эрт илрүүлэхэд өдөр тутамд эцэг эхийн анхаарал чухал болохыг тайлбарлан, энэ талаар байнга ажиглаж байхыг зөвлөнө.</li> </ul>
----------	---

## 7. Хүний нүд рүү эгцэлж хардаг уу?

Зорилго	Бусадтай харилцах эрмэлзлийг нь шалгах.
Шалгах арга	Тоглоом ашиглан хүүхэдтэй хамт тоглонгоо бусад хүүхэд, эцэг эх болон үзлэг хийж буй эмчийн нүд рүү харж инээмсэглэх, эсвэл харьцаж буй нөгөө хүнийхээ харсан зүг рүү дагуулан харж (Анхаарлаа ижилхэн хандуулах) буй эсэхийг ажиглана.
Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Хялар биш, нүдний алимны хөдөлгөөнд өөрчлөлт байхгүй боловч, хүний нүд рүү харахгүй, эсвэл хүнээс ямар нэг юм авах, гуйж хүсэхдээ харьцаж байгаа хүнийхээ нүд, нүүр өөд анхаарахгүй, харьцаж буй хүнийхээ харц болон хуруугаар заасан зүгт харах зэрэг хариу үйлдэл үзүүлэхгүй байвал аутизмын хүрээний эмгэгийн шинж байж болзошгүй. Энэ тохиолдолд, хүүхдийн эцэг эхдээ эрхэлж наалдах байдлыг ажиглах, асууж тодруулах зэргээр бусдаас бишүүрхдэг эсэх, ээжтэйгээ цуг байхдаа айж түгшдэггүй эсэхийг шалгана.</li> <li>- Мөн эцэг эхэд тулгардаг асуудлын (Хүүхэд өсгөж бойжуулахад явцад үүсдэг бухимдлаас үүдэлтэй сэтгэл зүйн асуудал г.м) улмаас хүүхэдтэйгээ сайн харилцаж, ажиллахаа болиход хүүхдийн эрхэлж наалдах үйлдэл тогтворгүй болох, эсвэл хэт хөдөлгөөн нь даамжрах хандлага үүснэ.</li> </ul>

## 8. Араас нь нэрээр нь дуудахад эргэж хардаг уу?

Зорилго	Сонголыг нь шалгах.
Шалгах арга	Хүүхдийг тоглох эсвэл цааш явж байхад араас нь нэрээр нь дуудна. Ингэхэд хүүхэд эргэж харах, хийж буй үйлдэл, хөдөлгөөнөө зогсоох зэргээр ямар нэг хариу үйлдэл үзүүлэх эсэхийг ажиглана. Нэрээр нь дуудахад хариу үйлдэл үзүүлэхгүй байвал, үгэн бус дуу чимээнд (хонх, бөмбөрийн дуу г.м) үзүүлэх хариу үйлдлийг нь шалгана. Мөн хамар битүүрэлт, дунд чихний үрэвсэл зэрэг эмчийн онош дүгнэлт байгаа эсэхийг эцэг эхээс нь асууж тодруулна.
Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Хэрэв сонголд нь асуудал илэрвэл, өмнө нь дунд чихний үрэвсэл болон хамрын хөндийн үрэвсэлтэй байсан эсэх, чихэнд нь хүрэхэд хүүхэд зовиурлаж байгаа эсэх, чихнээс нь булаг гардаг эсэх, зурагт болон дуу өсгөгчид хэт ойртож сонсдог эсэхийг эцэг эхээс нь асууж тодруулна. Зарим ямар нэг өвдөлт зовиургүй, булаг гоождоггүй дунд чихний үрэвсэл (дунд чихэнд бугласан идээт үрэвсэл) байдаг.</li> <li>- Ялангуяа, дауны хам шинжтэй хүүхдүүд дунд чихний үрэвслээр өвчлөмтгий байдаг. Нярай болон бага насны хүүхдийн сул сонсгол нь хэл ярианы хөгжилд сөргөөр нөлөөлдөг талаар эцэг эхчүүдэд тайлбарлан, мэргэжлийн эмнэлэгт үзлэг оношилгоо хийлгэхийг зөвлөнө.</li> </ul>

## 9. Шүдээ угаахыг зааж өгөхөд дуурайж байна уу?

Зорилго	<p>Дараах 2 үндсэн зорилготой.</p> <p>а. Амны хөндийн эрүүл мэнд гэдэг утгаар, эцэг эхийн шүд угаахтай холбоотой мэдлэг ойлголт, гэртээ шүд угаах дадлыг хэрхэн хэвшүүлсэн талаар нь тодруулах.</p> <p>б. Хүүхдийн танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжил дэх бусдын үйлдлийг дуурайх хүсэл сонирхол, дуурайх чадвар болон дуурайж сурах чадвар, хэрэглэгдэхүүн ашиглах сонирхол, хэрэглэгдэхүүн ашиглах чадвар зэргийг нь шалгах.</p>
---------	--



Шалгах арга	<p>Гэртээ шүдээ угааж хэвшсэн эсэх болон хэрхэн угаалгадаг талаар эцэг эхээс нь асууна. Хэрэв шүдийг нь угаалгадаггүй бол, хооллосны дараа амыг нь зайлуулдаг, эсвэл цэвэр ус болон буцалсан ус уулгадаг зэргээр амны хөндийн эрүүл мэндийг нь сахиж буй эцэг эхийнх нь ойлголтыг шалгана (а). Мөн эцэг эх нь хүүхдийнхээ шүдийг угааж өгдөг боловч “Шүдээ угаах талаар зааж өгөөгүй”, “Заасан ч дуурайж угаадаггүй” гэж хариулсан тохиолдолд, томчуудын өдөр тутам хийж буй үйлдлийг хараад хүүхэд өөрөө дуурайж хийдэг болсон зүйл, хүнээр заалгаж сурсан зүйл байгаа эсэхийг асууж тодруулна (б). Эрүүл мэндийн үзлэг хийж буй эмч өөрөө хүүхэдтэй шууд харьцан тоглоом хөдөлгөж, хэрхэн тоглохыг харуулаад хүүхэд дуурайх эсэхийг эсэхийг ажиглана.</p>
Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийнхээ шүдийг сойзоор угаадаггүй бол, амны хөндийг нь цэвэрлэх, шүд цоорохоос урьдчилан сэргийлэхийн тулд шүдийг нь угааж хэвшихийн чухлыг эцэг эхэд нь хэлж өгнө. Шүдээ угааж үзээгүй хүүхдэд шүд угаахыг шууд заалгүй, шүдээ угаах дургүй болгохгүйн тулд өдөр бүр тогтмол угааж сургах нь зүйтэй. Хүүхдийн хүсэлд нийцүүлэн өөрөөр нь угаалгаж болох хэдий ч, эцэст нь заавал том хүн дуусгах ёстой гэдгийг хүүхдэд хэлж ойлгуулна (а).</li> <li>- Дараа нь, өдөр тутамд томчуудын үйлдлийг дуурайх байдал бараг ажиглагдахгүй байвал, Хөгжлийн үзүүлэлтийн 2)-т дурдсан “Хэл ярианы хөгжил”, 7)-д дурдсан “Бусадтай харилцах эрмэлзэл” 6), 8) дахь “Нүдний хараа, сонсгол” зэрэг үзүүлэлт нь ямар байсантай жишин, цаад учир шалтгааныг судална. Танин мэдэхүйн хөгжлийн хоцрогдол болон эцэг эхдээ эрхэлж наалдах харилцааны дутмаг байдал, бусадтай харьцах эрмэлзэл хангалтгүй байгаа эсэхийг анзаарангаа сайтар ажиглана. Хүүхдийн хөгжлийн түвшинд тохируулан, эцэг эх нь хүүхэдтэйгээ ямар нэг тоглоом, эд зүйл ашиглан харилцаж тоглох тоглоомын аргуудаас танилцуулж болно.</li> <li>- Анхаарах шаардлагатай зүйл нь, энэ насны хүүхдэд дуурайж хийхийг хүчлэх, заах гэж улайрвал хүүхдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлдөг тул, том хүнтэй харилцах энгийн бөгөөд зугаатай харилцаан дунд хүүхэд өөрөө идэвхтэй дуурайж эхлэхийг хүлээх хэрэгтэй.</li> </ul>

## 10. Хүүхэд ямар зүйл оролдох дуртай вэ?

Зорилго	<p>Дараах 2 үндсэн зорилготой.</p> <p>а. Хүүхдийн тоглож буй байдлаас танин мэдэхүй, хэл яриа, гар хуруугаа удирдаж хөдөлгөх чадвар, мэдрэмтгий байдал, бусадтай харилцах хөгжил зэргийг нь шалгах.</p> <p>б. Эцэг эх нь хүүхдийнхээ сэтгэл санааны байдал, зан үйлд хэр анхаарч, хэр ойлгодог болох, гэртээ хүүхэдтэйгээ хэр их хамт тоглодог талаар шалгах.</p>
Шалгах арга	<p>Гэртээ хүүхдийн дуртай хийдэг зүйлийг (тоглоом) эцэг эхээс нь асууна. Хэдийд, хэнтэй, хэр удаан хийдэг зэргийг нь нарийн асууна. Мөн эцэг эх нь хүүхэдтэйгээ ямар тоглоом тоглодог тухай дэлгэрэнгүй асууж тодруулна. Эрүүл мэндийн үзлэг хийж буй эмч нь, хүүхэд ямар тоглоомоор хэрхэн тоглож буйг бодитоор ажиглан, хүүхдийн тоглоом, эд зүйлийг ашиглаж буй байдал, бусадтай харилцаж буй байдалд нь сэжигтэй зүйл байгаа эсэхийг шалгана.</p>
Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд 18 сар орчимтой болоход, модон шоог алим, эсвэл машин болгон орлуулж тоглох, айл гэр болж тоглодог тоглоомоор тоглон хоол хийх, хоолоо аягалах зэргээр тоглох, эсвэл хүүхэдтэйгээ тэврээд юм ярих зэргээр төсөөлөн тоглож эхэлдэг.</li> <li>- Мөн том хүнтэй хамт тоглохыг хүсэх, дуртай тоглоомоо авч ирээд тоглохыг гуйдаг болно.</li> <li>- Ингэж төсөөлж тоглох янз байдал ажиглагдахгүй, том хүнтэй хамт тоглохыг хүсэхгүй байвал, танин мэдэхүйн хөгжил болон бусадтай харилцах харилцааны хувьд хоцрогдолтой гэж үздэг.</li> <li>- Гэр бүлийнхэн нь хүүхэдтэйгээ тоглох цаг хомс байдаг тохиолдолд, өдөр бүр бага ч болов цаг гарган хүүхэдтэйгээ харьцаж тоглохыг зөвлөнө.</li> <li>- Мөн хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн болон бусадтай харилцах харилцааны хоцрогдол сэтгэлийг нь зовоож байгаа бол эрүүл мэндийн үзлэгийн дараах нэмэлт дэмжлэг болгон эх хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагаанд хамруулан хөгжлийн явцад тогтмол ажиглалт хийх, олон төрлийн тоглоомын аргуудаас танилцуулах нь зүйтэй.</li> </ul>

## 11. Мэддэг зүйлийг нь асуухад хуруугаараа зааж чадаж байна уу?

Зорилго	Танин мэдэхүй, хэл ярианы хөгжил болон бусадтай харилцах харилцааны хөгжилтэй холбоотой “Хуруугаар зааж хариулах” чадварыг шалгах.
Шалгах арга	Өдөр тутамд хүүхдийн сайн мэддэг зүйлийнх нь талаар зурагтай ном, зурган карт ашиглан “...аль нь вэ?” гэж асуухад, хүүхэд зөв хариултыг хуруугаар зааж буй эсэхийг шалгана. Хэрэв хуруугаараа заахгүй байвал, зурган картаа бодит зүйлтэй нь цуг харуулаад “... аваад өг дөө” гэж хэлэн гараа сунгахад, хүүхэд зөвийг нь авах, эсвэл эмчид авч өгөх эсэхийг ажиглана. Хүүхэд биеэ бариад байвал эцэг эхээр нь асуулгасан ч болно.
Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Энэ даалгаврыг биелүүлэхэд дараах үндсэн 2 чадвар шаардагдана. Эхнийх нь аливаа зүйлсийн нэрийг ойлгох танин мэдэхүй, хэл ярианы чадвар бөгөөд нөгөөх нь харьцаж буй хүнийхээ асуултад ойлгомжтой байдлаар хуруугаар зааж хариулах бусадтай харилцах харилцааны чадвар юм. Мөн том хүнтэй хамт тоглохыг хүсэх, дуртай тоглоомоо авч ирээд тоглохыг гуйдаг болно.</li> <li>- Хэрэв эд зүйлийн нэрийг асуухад зургийг заах болон бодит зүйлд анхаарлаа хандуулж, эсвэл гар хүрч байвал тухайн үгийг ойлгож байна гэж үзнэ. Үгийг нь мэддэг ч хуруугаар зааж хариулахгүй байвал, аутизмын хүрээний эмгэгийн үед илэрдэг бусадтай харилцах чадвар сул байх магадлалтай.</li> <li>- Асуултад хариулахаас бусад тохиолдолд хуруугаар заадаг эсэхийг ажиглан, харьцангуй багаасаа сурдаг том хүний хуруугаар заасан зүгт анхаарлаа хандуулж байгаа эсэх, том хүнд хандаж санаагаа илэрхийлэх, хүсэж байгаа зүйлээ хуруугаар зааж байгаа эсэхийг нь шалгана.</li> <li>- Өдөр тутамд хүүхдийн хүсэл сонирхолд нийцүүлэн эелдгээр яриа өдөх, эсвэл хооллох, хувцсаа солих үед нь хүүхдэд 2 зүйлээс аль дуртайгаа сонгох сонголт бий болгож өгөх, дуртай тоглоомоор нь хамт тоглох зэргээр хүнтэй харилцах боломжийг аль болох нэмэгдүүлж, хүүхдийн хийх үйлдлийг ихэсгэх аргуудаас зөвлөж болно.</li> <li>- Аутизмын хүрээний эмгэгийн шинж тэмдгийн тухайд, Хөгжлийн үзүүлэлт 7), 10) дахь үзүүлэлтэд ямар байсантай харьцуулж үзнэ.</li> </ul>

## 12. Биеийн эрхтнээ мэддэг үү? Жишээ нь “Амаа ангай”, “Хэлээ гарга” гэхэд ойлгох уу?

Зорилго	Биеийнхээ эрхтнүүд болон үйлдэл хөдөлгөөний (Үйл үг) талаар ойлгодог эсэх, хялбар зааврыг ойлгодог эсэхийг шалгах.
Шалгах арга	Биеийн эрхтний тухай ойлголтыг нь шалгахдаа, “... хаана байна вэ?” гэж нүд, хамар, ам, чихийг нь асуухад, өөрийнхөө бие, эсвэл хүүхэлдэйн дээр багаар бодоход нэгийг зөв зааж болно. “Амаа ангай”, “Хэлээ гарга” гэсэн жишээ асуултын тухайд, 18 сар хүрч байгаа хүүхэд үйл үг хараахан сайн ойлгохгүй учир хариулж чадахгүй байх нь тийм ч ноцтой асуудал биш юм.
Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- 18 сартайгаас 2 нас хүртэл хүүхэд өөрийн биеийн эрхтнээс мэддэг болж эхэлнэ.</li> <li>- 18 сартайдаа биеийн аль ч эрхтнээ мэдэхгүй байвал, Хэл ярианы хөгжлийн (Үг ойлгох) хоцрогдолтой байж болзошгүй тул хөгжлийн үзүүлэлт 2), 8), 11)-т дурдсан үзүүлэлттэй жишиж үзнэ.</li> <li>- Биеийн эрхтний тухай ойлголт муутай байгаа бол, эцэг эх нь хүүхэдтэйгээ хамт биеийн эрхтний нэр орсон дуу дуулах, эсвэл хүүхэлдэйгээр тоглож болно.</li> <li>- Мөн биеийнхээ эрхтнүүдийн нэрийг цээжилж эхэлж байгаа хүүхдэд “Амаа ангаагаарай”, “Хэлээ гаргаарай”, “Нүдээ ань” гэх зэргээр үйл үг залган хэлж тогловол, үйл үг ойлгох болон 2 үгтэй холбоо үг ойлгох чадвар нь хөгжинө.</li> </ul>

## 13. Бусад хүүхэдтэй хамт тоглодог уу?

Зорилго	18 сартай хүүхэд ганцаараа сайн алхаж сурсан байдаг тул эцэг эх нь хүүхдээ гадаа салхилуулах, эсвэл тоглоомын талбайд дагуулж очоод танихгүй хүүхдүүдтэй харилцах боломжийг аль болох олон болгох хэрэгтэй. Бусад хүүхэдтэй хамт тоглож арай чадахгүй ч, хүүхэд олонтой газар аль болох их дагуулж очдог эсэхийг нь шалгана.
Шалгах арга	Эцэг эхээс нь асууна. Эрүүл мэндийн үзлэгийн үед бусад хүүхэдтэй хэрхэн харьцаж байгааг нь ажиглана.
Зөвлөгөө	- 1 настай хүүхдүүд хамт тоглохыг “Зэрэг тоглох” гэж нэрлэх бөгөөд нэг газарт ижил тоглоомоор яг адилхан тоглож байгаа юм шиг харагдах ч, хоорондоо огт харилцахгүй, зөвхөн цуг ирсэн таньдаг хүнтэйгээ тоглохыг хэлнэ.

Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- 18 сар хүрээд “Зэрэг тоглох”-доо тоглоомоо булаацалдаж, асуудал үүсгэх байдлаар хоорондоо харьцаж эхэлдэг. Иймэрхүү асуудал үүсвэл, том хүн дундуур нь орж “Түр өгч бай даа” гэж нөгөө хүүхдээсээ хүсэх, “Хамтдаа тоглоё” гэж гуйх талаар үлгэрлэн үзүүлбэл, цаашид хэл яриа болон хамт тоглох чадвар нь хөгжихөд тустай.</li> <li>- Ихэнх цагийг хүүхэдтэйгээ гэртээ өнгөрүүлдэг эцэг эхчүүдэд хүүхдээ аль болох гадаа, тоглоомын талбайд дагуулж очиж байхыг зөвлөх нь зүйтэй.</li> <li>- Мөн олон хүүхэд тоглож байгаа газарт айж бишүүрхэн эцэг эхээсээ холдохгүй, тоглоомонд ойртож гар хүрэхгүй байгаа хүүхэд болон эсрэгээрээ эцэг эхээ ч, бусад хүүхдийг ч огт анзаарахгүй тоглож, ийш тийш гүйж харайгаад байдаг хүүхдэд эцэг эхдээ эрхэлж наалдах, бусад хүнийг таних, нийгэмших зэрэг хөгжилд нь асуудал байж болзошгүй.</li> <li>- Хэт айж бишүүрхдэг хүүхдийн хувьд, эцэг эх нь хамт дагуулан хүүхдүүдийн дунд оруулах, эсвэл хүүхэд өөрөө хүсэх хүртэл нь байдлыг ажиглан хүлээж болно гэж зөвлөнө.</li> <li>- Эргэн тойрноо огт анзаардаггүй, хэт хөдөлгөөнтэй, хэт цочмог ширүүн ааштай хүүхэд бол, өөрөө гэмтэж бэртэх, эсвэл бусад хүүхдүүдэд аюултай үйлдэл гаргахгүй байхад анхаарч, сэрэмжтэй байхыг зөвлөнө.</li> </ul>
----------	--

#### 14. Таньдаг хүнтэйгээ ярих дуртай юу?

Зорилго	Бусадтай харилцах эрмэлзэл, дур сонирхол ба харилцааны арга хэрэгсэл, сонсох чадварын хөгжилд нь санаа зовоосон асуудал бий эсэхийг шалгах.
Шалгах арга	Эцэг эхээс асууна. Мөн хүүхдийн эцэг эхтэйгээ харилцах байдалд ажиглалт хийнэ. Энд дурдсан “Ярих” гэдэг үгийн утга нь зөвхөн үгээр санаа бодлоо дамжуулах хэл ярианы чадвартай (Үг хэллэг, дүрэм) гэсэн үг биш бөгөөд бусадтай биеийн хөдөлгөөн, гар хуруугаараа дохин дуу авиа гаргаж харилцах дуртай эсэх тухай асуудал юм. Тухайлбал, хүүхэд өөрөө ямар нэг дуу авиа гарган харьцахад нь том хүн өөдөөс нь хариу хэлж, инээмсэглэхэд хүүхэд ч мөн баярлаж, хүний хэлсэн үгийг дуурайх зэргээр 2-оос дээш удаа харилцан ойлголцож байгаа эсэхийг шалгана.

Зөвлөгөө

- Энэ насны хүүхэд хааяа нэг утгатай үг оролцуулан гар хуруугаар заах, биеийн хөдөлгөөн ашиглах зэргээр дуу авиа гаргаж, харилцан ярилцаж байгаа мэт дүр үзүүлэх дуртай болж эхэлдэг. Яг ийм үед нь хүүхдийн бодлыг уншиж ойлгон, тохирох үгээр нь хариу хэлэхэд, хүүхэд тэр үгийг дуурайн хэлэх замаар аяндаа хэл яриа нь хөгжиж ирдэг. Мөн хүнтэй ингэж харилцахыг хүсэх (Гэрийн хэн нэгэн, цэцэрлэгийн асрагч г.м) байдал ажиглагдах бөгөөд үүнийг нь нийгэмшихүйн эхлэл тавигдаж байна гэж үзэж болно.
- Нөгөө талаар, эцэг эх нь цуг байсан ч өрөөн дотуур нааш цааш холхих, эсвэл тоглоомоороо ганцаараа тоглох зэргээр эцэг эхээ дэргэд нь байхгүй мэт янз гаргах, эсвэл хамт тоглосон ч үргэлжлүүлэн тоглохгүй байвал бусадтай харилцах эрмэлзэл сул байгаагийн шинж гэж үзнэ.
- Гэхдээ эцэг эх нь өөрсдөө хүүхэдтэйгээ олигтой харилцахгүй тохиолдол ч байдаг тул зөвхөн хүүхдийнхээ онцлогт анхаараад байлгүй, эцэг эх нь хүүхдийнхээ санаа бодлыг мэдэрч ойлгох чадвар болон хүүхдийн үгэн бус, ойлгомж муутай хандлагыг нарийн мэдэрч хариулж буй эсэхийг ажиглах шаардлагатай.
- Эцэг эх нь хүүхэдтэйгээ хамт тоглохын чухлыг ойлгуулж, хүүхэдтэйгээ зөвхөн дуу авиа, хэл яриагаар харилцах гэлгүйгээр, дуу авиа, хэл яриандаа бие болон хуруу, гарын хөдөлгөөн оролцуулан хүүхдэд ойлгомжтой байдлаар харилцахыг зөвлөнө.
- Зөвхөн хүүхэд өсгөх хүмүүжүүлэх асуудал төдийгүй, гэр бүл болон ажил төрөлтэй холбоотой эцэг эхэд нь сэтгэл зовних зүйл, бухимдалтай байгаа бол сэтгэл зүйн дэмжлэг шаардагдах тохиолдол ч байж магадгүй. Мөн бусадтай биеийн хөдөлгөөн, нүүрний хувирлаараа харилцах дуртай боловч бараг дуугардаггүй, том хүний хэлснийг давтаж хэлдэггүй бол сонсголын асуудалтай байж болзошгүй тул, үзүүлэлт 8) дээр ямар байсантай жишиж үзнэ.

## 15. Тэврэхэд өөдөөс тэвэрдэг үү?

Зорилго	Эрхэлж наалдах холбоо үүссэн эсэх, хэт мэдрэмтгий байгаа эсэхийг шалгах.
Шалгах арга	Эцэг эхээс нь асууна. Мөн хүүхэд сайхан ааштай үедээ эцэг эхтэйгээ хэрхэн харьцаж байгааг ажиглана. Эцэг эх, асран хамгаалагч зэрэг итгэлтэй хүн нь тэврэхэд баярладаг эсэх, хүүхэд өөрөө тэврээд баярлаж байгаа эсэхийг харна.
Зөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Энэ үзүүлэлтэд анхаарал татдаг хүүхэд гэдэг нь тэврэх гэхэд дургүйлхэж харц буруулдаг хүүхдийг хэлнэ.</li> <li>- Энэ тохиолдолд, хүүхэд эцэг эхдээ тэврүүлэх гэх, эсвэл үүрүүлэх гэж зүүгдэх эсэхийг анхааралтай ажиглана.</li> <li>- Эцэг эх нь тэврэхэд дургүйцдэг, эсвэл ямар нэг нүүрний хувирал үзүүлэхгүй боловч, эцэг эхээ яг л сандал мэтээр өвдөг дээр нь гарч суух, морь унах гэж байгаа юм шиг мордчихдог хүүхэд ч бий. Ийм тохиолдолд, бусадтай харилцах эрмэлзэл, бусдыг таних чадвар сул байх магадлалтай бөгөөд хүүхдийн хөгжлийг анхаарч дэмжлэг үзүүлэх шаардлагатай.</li> <li>- Мөн өөрөө бусдын биед зүгээр гар хүрдэг ч, бусад хүн биед нь хүрэхэд дургүйцдэг хүүхдүүдийн зарим нь хүрэлцэхүйн хэт мэдрэмжтэй байх нь бий. Зөвхөн дуртай хоолоо л иддэг, эсвэл шүдээ угаах, усанд орохдоо нүүрээ норгох маш дургүй, хувцасны зарим даавуунаас хэт дургүйцдэг болон бусад хэт мэдрэмтгий шинж байдал илэрч байгаа эсэхийг шалгана.</li> </ul>

## 16. Аав ээжтэйгээ тоглохдоо инээдэг үү? Чангаар инээж хөхөрдөг үү?

(1) Зорилго, (2) Шалгах арга, (3) Зөвлөгөө нь, үзүүлэлт 14) болон 15)-д дурдсантай ижил тул, энэ 2 үзүүлэлтэд ямар байсантай жишиж үзнэ.

# 3


## 18 САРТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГ БА ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙ

### 1. 18 САРТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ

Энэ бүлэгт 18 сартай хүүхдийн хөгжлийн онцлогийг 1) Том булчингийн хөдөлгөөн, 2) Танин мэдэхүй, гар хурууны хөдөлгөөнөө удирдах байдал, 3) Хэл яриа, бусадтай харилцах байдал, 4) Тоглох байдал ба нийгэмшихүй гэсэн 4 айд хуваан тус бүрийг дэлгэрэнгүй тайлбарласан.

#### 1) Том булчингийн хөдөлгөөн

Хүүхдүүдийн хөлд орох хугацаа харилцан адилгүй байдаг. Гэхдээ 18 сартай бүх хүүхдийн 90-ээс дээш хувь нь хэдийнэ хөлд орчихсон байдаг. Хүүхдийн алхаж сурах нь “Эргэж хөрвөөх (5-7 сартайд) → Суух → Мөлхөх → Түшиж босох → Дамжих (7-12 сартайд) → Түшихгүй зогсох → Алхах (15 сартайд)” зэрэг үе шатыг дамжих бөгөөд энэ үйл явц нь хүн зааж өгснөөр сурчихдаг зүйл биш. Хүүхэд биеэ чөлөөтэй хөдөлгөн, өөртөө харагдсан зүйл рүү сонирхон тэмүүлж, гар нь хүрэхгүй байгаа зүйлд дөхөж очих зэргээр өөрөө аяндаа хөлд орно. Хүүхэд 18 сараас 2 нас хүртлээ шатны бариулаас бариад өгсөж уруудах, эсвэл аажуухан гүйж сурдаг.






## 2) Танин мэдэхүй, гар хурууны хөдөлгөөнөө удирдах байдал

Зарим хүүхэд 10 орчим сартайдаа, бутархай жижиг биетийг эрхий хуруу ба долоовор хуруугаараа чимхэж авч чадах бөгөөд авсан зүйлээ хайрцаг, саванд хийж гаргах зэргээр тоглох дуртай болдог. Нэг нас хүрэхэд, хүний заасныг дуурайн модон шоо давхарлаж өрөх, эсвэл харандаагаар сараачиж зурж сурна. Харин 18 сартайдаа нүд, гарын хөдөлгөөний уялдаа нь улам сайжирч, 3 ширхэг модон шоог давхарлаж өрөх, хоолоо халбагаар авч идэх зэрэг үйлдлүүдийг сурч, тоглоом хэрэгслийг ашиглаж чаддаг болж эхэлнэ. Түүнчлэн ой тогтоолт сайжирч, 2-3 ширхэг хайрцагны аль нэгд нуусан зүйлийг сайн тогтоож, нуусны дөнгөж дараахан нь асуухад зөв олж чаддаг. Мөн гурвалжин, дөрвөлжин зэрэг үндсэн дүрсийг ялган ойлгож, ижил дүрсүүдийг нийлүүлэх, хэвэнд дүрс тааруулах зэргээр хялбар тоглоомоор сонирхож тоглох нь ажиглагдана.

## 3) Хэл яриа, бусадтай харилцах байдал

Хэл ярианы хөгжлийн эхний шат бол, 0-12 сартай хүүхдийн үг цээжилж эхэлдэг “Хэлд орохын өмнөх үе” юм. Хүүхэд хэлд ороогүй байхдаа утгатай үг (Үгээр илэрхийлэх) хэлж чадахгүй ч, үгэн бус харилцааны аргаар том хүний хэлсэн үг болон утгын хувьд хоорондоо холбоотой, сонсоход ойлгомжтой зарим хялбар үгийг (Хэл яриа ойлгох) цээжилж эхлэх бөгөөд энэ үеэс аажмаар утгатай үг хэлж сурна (Үг хэлж эхлэх). Нэг нас хүрээд ганц нэг үг хэлж сурах ба гол төлөв нэр үг нэмэгдэж, харьцаж буй хүндээ өгүүлбэртэй төстэй, янз бүрийн утгатай цөөн үг хэлж сурах “Нэг үгээр ярьдаг үе” хэмээх дараагийн шатанд шилждэг. 2 настай хүүхдүүдийн бараг тал хувь нь 2-оос дээш үг холбон ярьж сурдаг. Харин 18 сартайдаа хэлснийг ойлгох, үгээр өөрийгөө илэрхийлэх чадвар нь сайжран холбоо үг хэлж сурах бөгөөд энэ нь дүрэм сурч эхлэх чухал үе юм.



Энэ үе дэх хэл ярианы хөгжлийн суурь нь бусадтай харилцах үгэн бус харилцааны чадвар бөгөөд нэг нас дөхөөд ирэх үеэс ихэнх хүүхэд “хамтдаа анхаарах” чадвартай болсон байх ба бусдыг дуурайх, хуруугаар заах зэрэг чадвар нь хөгжлийн чухал үзүүлэлт болно. “Хамтдаа анхаарах” гэдэг нь дэргэд байгаа хүнийхээ анхаарч буй зүйлийг нүдний харц, зааж буй хурууг нь дагуулан харж анхаарах чадвар юм. “Хамтдаа анхаарах” чадварыг хүний хуруугаар заасан зүг рүү хүүхэд харж байгаа эсэхээр шалгадаг. Мөн хүүхдийн өөрөө хуруугаар заах чадвар нь нэг нас хүрэхийн өмнө, аливааг хүсэж шаардах эсвэл санаагаа илэрхийлэхдээ хуруугаар зааж (сонирхсон зүйл рүүгээ хуруугаараа зааж илэрхийлэх) эхлэх байдлаар ажиглагдана. Нэг настай хүүхэд аливаа хүсэж байгаа зүйлээ болон хүний асуултад хариулахдаа хуруугаар заах, санаагаа бусдад ойлгуулахын тулд хуруугаар зааж эхэлдэг. Мөн утгатай үг хэлж эхлэх “Нэг үгээр ярьдаг үе”-дээ ирэхэд үг хэлэх, хуруугаар заахыг хослуулдаг.

Ихэнх хүүхэд 12 сар орчимтойдоо утгатай үг хэлж эхлэх ба 18 сар хүрэхэд нэг удаад 3 үг хэлж чаддаг болсон байдаг. Үгээр өөрийгөө илэрхийлж сурах үедээ, гол төлөв өөртөө ойр зүйлийн нэрийг хэлж сурдаг ч “Баяртай”, “Үгүй”, “Надад өгөөрэй” зэрэг бусадтай харилцахад ашигладаг үгийг ч мэддэг болсон байна. 2 нас дөхөхөд, биеийнхээ эрхтнээс наанадаж гурвыг мэддэг болох төдийгүй, “... аваад ир” гэх мэт том хүний хэлсэн хялбар зааврыг ойлгож биелүүлнэ.

#### 4) Тоглох байдал ба нийгэмшихүй

Гэр бүлийн өдөр тутмын амьдрал дунд, хүүхдүүд тухайн насныхаа хөгжлийн үе шатанд тохирсон сонирхлын дагуу эргэн тойрныхоо хүмүүс, эд зүйлтэй идэвхтэй харьцаж, биеийн болон гар хурууны хөдөлгөөний эвсэл, танин мэдэхүй, хэл ярианы чадвар нь хөгжсөөр байдаг. Ээждээ эрхэлж наалдах харилцааг аль болох эрт бий болгох нь хүүхдийн хожмын нийгэмшихүй, танин мэдэхүйн хөгжилд тун чухал юм. Хүүхэд ээжтэйгээ хамт байхдаа айж түгшихгүй, тайван байж чадах бөгөөд шинэ зүйл, шинэ орчин, шинэ хүмүүстэй харьцан бүх зүйлтэй танилцдаг. 18 сартай хүүхэд ганцаараа сайн явж сурсан байх ба үйлдэл хөдөлгөөн хийх орон зай нь өмнөхөөсөө улам тэлж, аав ээжээсээ хол байсан ч аливаа үйлдэлд зугуухан дасдаг. Аав ээж нь хүүхдийнхээ үйлдэл, хөдөлгөөнийг хориглож болиулах нь ихсэх тусам “Үгүй” гэж зөрүүдэлдэг болно. Энэ мэтчилэн эцэг эхтэйгээ харилцахад үүсдэг зөрчил дундаас хүүхэд бусдын талаар ойлголт авч эхэлдэг. Үеийнхээ хүүхдүүдийн талаар ч ойлголттой болж, тоглож байгаа хүүхдүүдийг шохоорхон хамт тоглохыг хүснэ. Гэвч бусад хүүхэдтэй харьцах, хэрхэн эв найртай тоглох учраа олохгүй, тоглоом болон эд зүйлээ булаалдах нь нийтлэг. Мөн томчуудын үйлдлийг зүгээр дуурайх биш, тэр хүн юу бодож, ямар зорилгоор хийж байгааг ч ойлгож эхлэх ба тоглоом, хэрэгслийн зориулалт, хэрхэн ашигладаг талаар сурч мэдэж авдаг.

Хүснэгт 5. 18 сартай хүүхдийн хэвийн хөгжил /ай тус бүрээр/


Сарын нас	Том булчингийн хөдөлгөөн	Танин мэдэхүй, гар хурууны хөдөлгөөнөө удирдах байдал	Үг яриа	Нийгэмшихүй, тоглох байдал
13-15 сартай	<ul style="list-style-type: none"> <li>- Шат, сандалд мацаж авирна.</li> <li>- Өөрөө 2, 3 алхана.</li> <li>- Бүжиг дуурайн биеэ хэмнэлтэй хөдөлгөнө.</li> <li>- Явган сууна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сараачиж зурна.</li> <li>- Унтраалга асааж унтраана.</li> <li>- Жижиг зүйлийг эрхий хуруу, долоовор хуруугаар чимхэж авна.</li> <li>- Халбага, шилэн аяга ашиглан өөрөө идэх гэж оролдоно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- “Надад өг дөө” гэхэд барьж байгаагаа өгнө.</li> <li>- Том хүний хуруугаар заасан зүгт харна.</li> <li>- Хуруугаараа зааж том хүнд харуулна.</li> <li>- Том хүний хэлсэн үг, биеийн хөдөлгөөнийг дуурайна.</li> <li>- Баяртай гэж даллана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бөмбөгөөр харилцаж тоглоно.</li> <li>- Аав, ээжийнх нь өвөр дээр өөр хүүхэд суухад уурлана.</li> <li>- Магтахад баярлан хийж буй зүйлээ давтана.</li> <li>- Нэрээр нь дуудахад эргэж харна, эсвэл хариу дуугарна.</li> </ul>
16-18 сартай	<ul style="list-style-type: none"> <li>- Ганцаараа 10 м-ээс хол алхана.</li> <li>- Нэг гараас нь хөтлөхөд шатаар өгсөнө.</li> <li>- Хэдэн алхам арагш ухарч алхана.</li> <li>- 3 дугуйтыг түрж тоглоно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- 2 ш модон шоог давхарлаж өрнө.</li> <li>- Тоглоомон машиныг гараараа өнхрүүлж тоглоно.</li> <li>- 2 ш аяганы аль нэгд нуусан зүйлийг олж чадна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- “Ээж нь хаана байна?” гэхэд хуруугаараа заана.</li> <li>- “... аваад ир” г.м хялбар зааврыг ойлгоно.</li> <li>- 2-оос олон үг хэлнэ. (Аав, ээж г.м)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Аав ээжийнхээ хариу үйлдлийг анзаарч хараад, дүрсгүйтнэ.</li> <li>- Аав ээжээсээ түр холдож тоглоно.</li> <li>- Үеийнхээ хүүхдэд дөхөж очно.</li> <li>- Тоглоомоо булаацалдана.</li> </ul>
19-21 сартай	<ul style="list-style-type: none"> <li>- Нэг гараас нь хөтлөхөд шатаар уруудна.</li> <li>- Гулсуурт авирч гараад гулсаж бууна.</li> <li>- Бөмбөг шиднэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- 3 ш модон шоог давхарлаж өрнө.</li> <li>- Тасралтгүй гогцооруулж зурж чадна.</li> <li>- Дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрсийг хэвэнд тааруулж хийнэ.</li> <li>- Шүдээ угаах гэж оролдоно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- 3-аас олон үг хэлнэ.</li> <li>- Зурагтай ном харуулаад “... хаана байна?” гэж асуухад хуруугаараа заана.</li> <li>- Нүд, чих, ам г.м биеийн эрхтнээсээ 2-оос олныг зааж чадна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэлдэйгээр тоглоно.</li> <li>- Найздаа тоглоомоо өгнө.</li> <li>- Бүгдийг өөрийн дураар хийх гэж зүтгэнэ, болиулах гэхэд дургүйцнэ.</li> <li>- Аав ээжээсээ хамт тоглох, ном уншиж өгөхийг гуйна.</li> </ul>

## 2. 18 САРТАЙ ХҮҮХДИЙН БИЕЙН БОЛОН СЭТГЭХҮЙН ХӨГЖИЛД АНХААРАХ АСУУДАЛ БА ТОМЧУУДЫН ОРОЛЦОО

Энэ хэсэгт 18 сартай хүүхдийн бие бялдрын хөгжилд зайлшгүй чухалд тооцогддог 1) Амьдралын зөв хэмнэл, 2) Харилцан итгэлцэл, 3) Амьдралын үндсэн дадлыг эзэмших, 4) Төрөл бүрийн тоглоом тоглох ач холбогдлын талаар дэлгэрэнгүй тайлбарлав.

### 1) Амьдралын зөв хэмнэл (Нойр, хоол, хөдөлгөөн)

Бага насны хүүхдийн бие махбод, уураг тархины эрүүл өсөлт бойжилт, хэвийн хөгжлийг дэмжихэд томчуудын оролцоо чухал бөгөөд хүүхдийг амьдралын зөв хэмнэлтэй болгоход ихээхэн үүрэгтэй. Ялангуяа нойр бол уураг тархины хөгжилтэй нягт уялдаатай тул нярайн хүүхдэд хоногийн 24 цагийг 1 мөчлөг гэж тооцон унтах, сэрэх зөв дадлыг бий болгож, хангалттай унтуулж нойр авахуулах нь хүүхдийн уураг тархины хөгжилд тун чухал юм. 24 цагийн ийм амьдралын хэмнэл (Физиологийн цаг) нь өдрийн ихэнхийг унтаж өнгөрүүлдэг нярайн төрсөн үеэс аажмаар бий болж, 4 сар орчимтойгоос өдөртөө сэрүүн байх, шөнө унтах хугацаа нь уртасч ирдэг. Нэг настай хүүхэд шөнийн ихэнхийг унтаж, өдрийн цагт 1 удаа унтаж, бусад цагт сэрүүн байх амьдралын үндсэн хэмнэлд дасна. 1-2 настай хүүхэд шөнө 11 цаг хагасаас 12 цаг хагасын хугацаанд унтаж амрах ёстой байдаг. Энэхүү амьдралын хэвшил нь аяндаа бүрэлдэхгүй бөгөөд гэр бүлдээ тогтсон зөв хэмнэлээр хүүхдийг өсгөж бойжуулах нь чухал юм. Өөрөөр хэлбэл, хүүхдийн уураг тархины эрүүл өсөлт, хөгжлийг хангах үндэс суурь нь эрт унтаж эрт босох, тогтсон цагт хооллох зэрэг амьдралын зөв дадал зуршил юм. Харин орой унтах, тогтмол цагт хооллохгүй байх зэрэг буруу дадал нь хүүхдийн боловсорч гүйцээгүй уураг тархины хөгжилд элдэв сөрөг нөлөө үзүүлж, эцэст нь бие махбодын өсөлт бойжилт, оюун ухаан, хөдөлгөөнд нь хоцрогдол үүсэх, сэтгэл санаа нь тогтворгүй болох, дархлаа сулрах зэрэг эмгэгийн шалтгаан болдог байна.




Томчуудын оролцоо гэдэг нь хүүхэд өдөртөө хангалттай үйлдэл хөдөлгөөн хийж, шөнөдөө сайтар унтаж амрах зөв хэмнэлтэй болоход том хүн хөндлөнгөөс нь тусалж дэмжих явдал юм. Хүүхдийг төрөхөөс өмнө насанд хүрэгчид амьдралынхаа хэв маягийг өөрчилж, гэр бүлийн бүх гишүүд хамтдаа хүүхэд төвтэй амьдралын хэмнэлийг бий болгох хэрэгтэй. Хүүхдийг шөнө сайн нойр авахуулахын тулд, унтахаас нь өмнө аль болох хоол идүүлэхгүй байх, шөнө чимээ шуугиан багатай байлгах, унтахад нь өрөөний гэрлийг унтраах, зурагт болон ухаалаг утасны гэрэл гаргахгүй байхад анхаарах шаардлагатай. Эрт сэрээж, цонхны хөшигөө нээн өглөөний наранд ээх, хөдөлгөөн хийлгэж нойрыг нь бүрэн сэргэсний дараа өглөөний цайг нь өгөх, бие засуулах зэргээр өглөөг тайван өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгөх нь зүйтэй. Харин өдөртөө аль болох тоглуулж хөдөлгөөнтэй байлгах, элдэв үйлдэл хөдөлгөөн, шинэ зүйл зааж өгөөд, түүнийгээ олон давтуулаад байвал хөдөлгөөн болон танин мэдэхүй, хэл ярианы хөгжил нь улам сайжирдаг.

## 2) Харилцан итгэлцэл (Эрхэлж наалдах харилцаа)

Дээр дурдсан амьдралын зөв хэмнэлээс гадна бага насны хүүхдийн хөгжилд ихээхэн утга учиртай зүйл бол эх хүүхдийн хооронд итгэлцэл бий болгох явдал байдаг. Хүүхдийг 0-3 настайд нь ээждээ эрхэлж наалдах харилцааг бүрдүүлснээр хожим насанд хүрээд бусад хүмүүстэй харилцах, нийгмийн амьдралд оролцоход чухал нөлөөтэй. Эрхэлж наалдах харилцаа үүсэх үе нь бүх хүнд ижил хариу үйлдэл үзүүлдэг үе (0-2 сар) → Хэн нэгнийг онцлон эрхэлж наалдах үе (3-6 сар) → Хэн нэгэнтэй үргэлж хамт байхыг хүсэх, тэр хүн нь байхгүй бол айж түгшдэг үе (6 сараас 2 нас) → Хэн нэгэнд илүү дотно, итгэдэг, тэр хүнээсээ хол байсан ч айж түгшихгүй, тайван байж чаддаг үе (3 нас орчимтой) гэж хуваана. Хүүхэд 2 настайгаасаа цэцэрлэгт орж, эцэг эх, гэрээсээ хол байж сурч эхэлдэг. 18 сартай хүүхэд дээрх 3 дахь үе шатанд очсон байх бөгөөд ээж хэмээх нөмөр нөөлөг дэргэд нь ойрхон байгаа эсэхийг анзаарангаа өөрөө явж сурах ба ээжээсээ зайгаа аажмаар холдуулсаар янз бүрийн эд зүйлийг хөдөлгөж барьж үзэн, танихгүй хүнтэй ч харилцаж эхэлдэг.

Томчуудын оролцооны зорилго нь хүүхэд айж түгшихгүйгээр бүх зүйлтэй танилцах, аливааг өөрөө сурч мэдэх боломжтой орчин бүрдүүлж өгөх явдал юм. Тухайлбал, хүүхэд гэмтэж бэртэх, юм андуурч уух, түлэгдэх гэх мэтийн асуудал үүсгэхгүйн тулд аюултай зүйл, осолтой газраас хол байлгах, хүүхдийг хараандаа байлгаж, хамтдаа цагийг өнгөрүүлэх боломжтой орчин бий болгох нь чухал. Мөн хүүхэд айж түгшсэн, ямар нэг асуудалтай тулгарвал аав ээждээ тэврүүлэхийг хүсэж, тусламж эрж байгаа зэрэг тохиолдолд, эрхэлж наалдах харилцаа гэсэн утгаар нь хэвийн хөгжил гэж ойлгон, хүүхдээ тэврээд хацраа наан илж тайтгаруулах хэрэгтэй. Мөн сайн мэдэхгүй орчин, танихгүй

хүүхдүүд тоглож байгаа газарт хүүхэд айж бишүүрхэн, аав ээжээсээ холдохгүй байвал, гараас нь хөтлөөд хамт тоглоход тайвширч, шинэ зүйлтэй танилцан сурч мэдэх бололцоотой болно.



Хөгжлийн аливаа асуудал анзаарагдсан зарим хүүхэд 18 сар хүрсэн ч ээждээ эрхэлж наалдахгүй (хацраа наах, инээж хөөрөх, тусламж хүсэх, холдоход түгших зэрэг), бүх хүнтэй нэг ижил байдлаар харьцдаг, аав ээж нь хамт байхгүй ч айж түгшихгүй, эсвэл аав ээжийгээ самардаж маажих, цохих гэх мэт өвөрмөц хандлага гаргадаг. Эдгээр тохиолдолд, эрхэлж наалдах ердийн харилцааг бий болгоход нь саад болж буй ямар нэг шалтгаан (хөгжлийн асуудал, эцэг эхийн хүчирхийлэл г.м) байж магадгүй тул анхааралтай ажиглах хэрэгтэй.

### 3) Амьдралын үндсэн дадлыг эзэмших (Хоол идэх, хувцас солих, усанд орох, гар нүүр, шүдээ угаах)

Хүүхэд 18 сар хүрэхэд алхаж явах, гар хурууны хөдөлгөөнөө удирдах болон ой тогтоолт, танин мэдэхүйн чадвар нь улам хөгжих бөгөөд өдөр тутмын зөв дадал, амьдралын хэмнэлтэй болсон байна. Хоол идэх, хувцсаа солих, усанд орох, гар нүүр, шүдээ угаах зэрэг амьдралын үндсэн дадал зуршил, чадвар эзэмших гэдэг нь, өмнөх “Аав ээж тусалдаг” гэсэн идэвхгүй байдлаас аажмаар “Өөрөө хийхийг хүсдэг” болж ирэх үеийг хэлдэг. Хоолыг халбага, сэрээгээр өөрөө идэх гэж оролдоно. Өмсөх дуртай хувцастай болох, өөрт нь хувцас өмсүүлэхэд эвтэйхэн болгохын тулд гараа дээш өргөж өгөх, хөлдөө

зай авах зэргээр зааж өгөөгүй байсан ч хувцаслахад өөрөө туслах үйлдэл үзүүлж эхэлдэг. Зарим хүүхэд усанд орох, гар нүүрээ угаахдаа өөрөө савандах, алчуураар арчих зэргээр аливаа зүйлийг зориулалтаар нь ашиглаж сурч эхэлнэ. Өмнөөс нь хүн хийж өгөх гэвэл дургүйцэж, өөрөө хийх гэж зүтгэнэ. Усанд орох, эсвэл шүдээ угаах дургүй хүүхэд бол том хүний байдлыг харж таамаглаад зугтах, эсэргүүцэх байдал ч гаргана. Эдгээр байдал ажиглагдаж байвал, амьдралын үндсэн дадал, бие даах үйлдэлд сургах болсны дохио бөгөөд хүүхдийнхээ чаддаг зүйлийг аль болох өөрөөр нь хийлгэх, хичээх бүрт нь магтаж сайшаах, хийсэн үйлдлийг нь сайн зааж, дуусгаж өгч хэвших нь чухал байдаг. Харин тухайн гэр бүлийн нөхцөл байдлаас шалтгаалан, өдөр тутамд дадал хэвшил болгож чадахгүй, хүүхдийн өөрөө хийх гэсэн хүслийг үл ойшоох, алдаа гаргахад нь загнаж буруушаавал хүүхэд өөрөө бие дааж сурахад саад болоод зогсохгүй, эцэг эхдээ итгэх итгэл бий болоход ч сөрөг нөлөөтэй.

### “Хүүхдийн шүдийг угаахад анхаарах зүйл”

Хүүхдийнхээ амны хөндийн эрүүл ахуйг сайтар сахижгүй бол сүүн шүд амархан цоорч, өвчлөх эрсдэл нэмэгдэнэ. Шүд цоорсноор хүүхэд идэх юмаа сайн зажилж чадахгүй, эсвэл ууж залгихад хүндрэлтэй болох ба зарим тохиолдолд авиа дуудлагад ч сөргөөр нөлөөлдөг. Шүдний цооролтоос сэргийлэхийн тулд амны хөндийн эрүүл ахуйг сахиж нь зорилгоор шүдийг сайтар угааж байх шаардлагатай.

**Хүүхдийг шүдээ угааж хэвшүүлэхийн тулд дараах дарааллаар шүдийг нь угааж байхыг зөвлөдөг.**

- Эцэг эхчүүд өөрсдөө өдөр бүр зугаатай байдлаар шүдээ угааж хүүхэддээ үзүүлнэ.
- Хүүхдийн сүүн шүд 7-8 сартай үед ургаж эхлэх ба эхлээд доод буйланд цухуйдаг. Энэ үеэс хүүхдээ өвдөг дээрээ дээш харуулан хэвтүүлээд, ургаж буй шүдийг нь сайтар ажиглах хэрэгтэй. Дараа нь хөвөн самбай зэргээр цэвэрлэж эхлэх ба ингэхдээ бүлээн усанд норгож чийглэсэн цэвэр самбайг долоовор хуруундаа ороон шүдийг нь зөөлөн зүлгэж цэвэрлэнэ. Хуруугаа аманд нь хэт гүн оруулж болохгүйг анхаараарай. Шүдэлж буй хэсэг болон шүдний завсрын бохир зэргийг хуруугаараа авч цэвэрлэх нь ч үр дүнтэй арга юм.
- Хүүхдийнхээ шүдийг самбайгаар цэвэрлэж сурсны дараа, хүүхдэд зориулсан жижиг, зөөлөн үстэй сойзыг шүдэнд нь хүргэх дасгалыг 1-2 удаа хийлгэнэ. Дасгал хийлгэснийхээ дараа хүүхдээ сайтар

магтаж урамшуулж байгаарай. Хэрэв хүүхэд тань дургүйцээд байвал шууд больж болно. Шүдээ угаах дургүй болгочихгүйн тулд анхаарч, янз бүрийн арга сэдэж болох юм. Ийм дасгалыг 1 сар орчим давтаарай.

- Хүүхэд тань аманд нь сойз хийхэд дасаад ирвэл, шүдийг нь угааж эхлэх цаг болсон гэсэн үг. Та сойзоо үзэгний барилтаар барьж угаах хэрэгтэй. Сайн харж байгаад шүдийг нь нэг бүрчлэн зөөлөн угааж өгөөрэй. Удаан ангайлгаад байвал ам нь чилнэ. Тиймээс 1 шүдэнд 5 секунд орчим хугацаа зарцуулахад хангалттай.

### Анхаарах зүйл:

- Амны хөндий маш мэдрэмтгий тул ихэнх хүүхэд аманд нь сойз хийхэд цааргалж дургүйцээд байдаг. Тиймээс хүүхдээ сайн магтаж урамшуулангаа дасгал хийлгэж, сойзонд нь дасгах замаар шүдээ угаах дуртай болгох нь нэн чухал юм.
- Сойзыг хүүхэддээ хамаагүй бариулбал ам руугаа гударч, амныхаа салстыг гэмтээж болзошгүй. Сойзыг аманд нь хэт гүн оруулахгүй байхад анхаарч, аюулгүй зөв угаах дадлыг хэвшүүлбэ.





## “Хүүхдийн хооллолт”

Бага насны хүүхдийн хооллолт нь зөвхөн шим тэжээл авахын тулд байдаггүй. Хүүхдийн хооллох дуршлыг бий болгох, амтлах мэдрэхүйг хөгжүүлэх гэсэн чухал зорилгуудыг ч агуулж байдаг. Тиймээс хүүхдийн хөгжилд тохируулан янз бүрийн хоол хүнс ашиглах, тэдгээрийг идэх аргад сургах, амтыг нь мэдрэх боломжийг бий болгож өгөх нь зүйтэй юм.

Хэл болон амны хөндийн бусад амтлах эрхтнүүд хүүхдийг эхийнхээ хэвлийд байхад бүрэлдэн тогтсон байх бөгөөд нярай хүүхэд ээжийнхээ сүүний амт өөрчлөгдөхийг маш нарийн мэдэрдэг гэж үздэг. Хүүхэд нэмэгдэл хоолонд орж эхлэх үеэсээ идэж чаддаг хоолны төрөл, хэмжээ нь ихэсдэг. Шинэ амт, үнэр, хоолноос авах мэдрэмжийг нь аль болох хөхиүлэн дэмжиж, хүүхдээ хоолонд дуртай болгохыг хичээх хэрэгтэй.

Хүүхдийн хооллолтын суурь 2-3 насанд тавигддаг. Өдөр бүр аль болох тодорхой цагт хооллуулж хэвших байдлаар амьдралын зөв дадалд сургах шаардлагатай. Хоолоор хэт шахах, эсвэл хэтэрхий удаан идүүлэх хэрэггүй. Гэхдээ, бага насны хүүхэд заримдаа хоолоо сайн иддэг, заримдаа бараг идэхгүй зэргээр янз бүр байдаг. Хүүхэддээ өгөх хөнгөн зууш, амттан зэргийг зөв сонгож, үндсэн хоолоороо хангалттай авч чадаагүй шим тэжээлийг нь нөхөх хэрэгтэй.

Хүүхдийн сүүн шүд 3 настайд ургаж гүйцдэг. Энэ үеэс хүүхэд араагаараа сайнажилж идэж сурах баажлуур булчин нь хөгжиж ирнэ. Бага зэрэгажлууртай, зөөлөвтөр зүйлийг яаралгүй тайванажлуулж идүүлэх хэрэгтэй. Хоолоо сайтаражилж идвэл эрүүний булчин нь хөгжиж, ясан шүд зөв ургахад нь сайн нөлөөтэй. Мөн хоол хүнснээс авах шим тэжээлийн хэмжээ нэмэгдэхэд ч үр дүнтэй байдаг.

Анхаарах зүйл:

- Гэр бүлээрээ хоолны ширээнд хамт суугаад харилцан ярилцангаа хооллох зугаатай уур амьсгалыг бий болгох нь ч чухал байдаг.
- Идэх дургүй зүйлийг нь жижиглэж хэрчих өгөх, өөрөөр амтлах зэргээр хүүхдийнхээ дургүйцэж магадгүй амтыг аль болох багасгахын тулд янз бүрээр өөрчилж болно. Ингэвэл идэх дургүй зүйлээ идэж чадсан гэсэн өөртөө итгэх итгэлийг хүүхдэд бий болгоход тустай.



#### 4) Төрөл бүрийн тоглоом тоглох (Танин мэдэхүй, нийгэмшихүй, хэл яриа)

Бага насны хүүхдийн тоглоом нь мэдрэхүй, хөдөлгөөн, танин мэдэхүй, нийгэмшихүй, хэл яриа зэрэг хөгжлийн бүх айд шууд холбогдоно. Тоглоом бол хүүхдийн хувьд аливааг сурч мэдэх боломж юм. Бага насны хүүхдийн хөгжил нь “Мэдрэхүй, хөдөлгөөний тоглоом (0-4 сартайд хуруугаа хөхөх, шажигнадаг тоглоом г.м) → Хөдөлгөж удирддаг тоглоом (5-8 сартайд шидэх, унагах, өнхрүүлэх, оруулж гаргах г.м) → Дагаж дуурайх тоглоом (9-11 сартайд үйлдлийг дуурайх, хэрэгсэл ашиглаж дуурайх г.м) → Орлуулдаг тоглоом (1 наснаас хойш модон шоог машин унаа болон идэх юм болгож орлуулах г.м) → Дүрд хувирдаг тоглоом (2 наснаас хойш айл гэр болж тоглох, баатрын дүрд тоглох г.м) → Дүрэмтэй тоглоом (4 наснаас хойш олуулаа тодорхой үүрэг, дүрмийн дагуу тоглох)” гэсэн дарааллаар ахиж өөрчлөгддөг.

18 сартай хүүхэд, өдөр тутамд том хүний үйлдлийг хараад, тухайн үйлдэл болон хэрэгсэл ашиглаж буй аргыг нь дуурайх, модон шоо эгнүүлж өрөх, давхарлаж тавих зэргээр өөрийн төсөөлсөн зүйл болгон орлуулж тоглох, эсвэл тоглоомон машинаа хөдөлгөж, “дүүд-дүүд” гэж дуугаран өөрийн мэддэг зүйлээ сэргээн төсөөлөх байдлаар тоглож эхэлдэг. Энэ маягаар бусдын үйлдлийг сонирхон дуурайх гэж оролдох, мэддэг зүйлээ зөвхөн санах бус дотроо төсөөлж, үйлдэл, дуу авиагаар сэргээж, орлуулж тоглох зэрэг чадвар нь хэл ярианы хөгжлийн чухал үндэс болно. Энэ насанд хүүхэдтэйгээ үргэлж хамт байж, хүсэл сонирхолд нь нийцүүлэн хүүхдийнхээ санаа бодлыг аль болох олон удаа өмнөөс нь төлөөлөн ярьж хэвших нь зүйтэй. Хэлэх зүйл нь ямар нэг зүйлийн нэр төдийгүй “Өө, эвдэрчихлээ”, “Дахиад хийе”, “Яасан

гоё амттай юм бэ”, “Аймаар байсан шүү” гэх мэтчилэн орчин нөхцөл, санаа бодлыг илэрхийлсэн үг хэллэгийг тухайн байдалдаа тохируулан хүүхдэд аль болох олон хэлж өгөх хэрэгтэй. Түүнчлэн “Өглөөний мэнд”, “Баяртай”, “Сайхан хооллоорой”, “Баярлалаа” зэрэг бусадтай мэндлэх, талархлын үгийг гэртээ дахин давтан хэлсээр байх явцын дунд хүүхэд сурч эхэлдэг.

Энэ насны хүүхэд зөвхөн үсэрч харайх, элс, усаар тоглох зэрэг хүрэлцэхүйг өдөөх мэдрэмж болон хөдөлгөөний тоглоомоор л тоглож, дуртай тоглоомоо эгнүүлэх, авч шидэх төдийхнөөр тоглоод байвал, танин мэдэхүй болон ой тогтоох чадварын хөгжил, бусадтай харилцахад (Нийгэмшихүй) нь хоцрогдол үүсэх магадлалтай. Тиймээс хүүхдийн онцлог, хөгжлийн үе шатанд тохируулан ажиллах арга зүйг эцэг эхэд нь зааж зөвлөх хөгжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ, эх хүүхдийг хамтад нь хөгжүүлэх үйл ажиллагаа зэрэг үйлчилгээг нэвтрүүлбэл тустай.

### 3. АСРАН ХАМГААЛАГЧДЫН АСУУЛТАД ХАРИУЛАХ

Энэ хэсэгт үзлэгийн үед асран хамгаалагчдын нийтлэг асуултад хэрхэн зөвлөгөө өгөх талаар танилцуулав.

#### Асуулт 1: Хүүхэд мөлхөхгүй, хөлд орохгүй байна?

Хөлд орох үйл явцын талаар дээр 3 дугаар бүлгийн “Том булчингийн хөгжил”-д дурдсан. Мөлхөхийн тулд, юуны өмнө биеийн байрлал болон мөлхөх хөдөлгөөний суурь болсон хүзүү, нуруу, хөлийн булчингийн хөгжил, урагш зүтгэхэд гар, хөлийн хөдөлгөөнийг уялдуулж өгдөг тархи мэдрэлийн системийн хөгжил, харсан зүг рүүгээ биеэ хөдөлгөх тэмүүлэл, сониуч зан зэрэг бүх хүчин зүйл бүрдсэн байдаг. Мөн заавал “Суух → Мөлхөх → Алхах” гэсэн дарааллаар хөгжих албагүй гэдэг тайлбар ч бий. Зарим хүүхэд үндсэн байрлалаар (Гэдсээ шаланд хүргэхгүйгээр, 2 гар болон 2 өвдөг дээрээ 4 хөллөх) мөлхөхгүй, “Хэвлийгээрээ мөлхөх” (Гэдсээ шаланд хүргээд тохойгоороо тулж урагшлах), “Өндийж мөлхөх” (Өвдгөө шаланд хүргэхгүйгээр урагшлах), “Бөгсөөрөө мөлхөх” (Суугаа байрлалаас гараараа тулан өгзгөөрөө урагшлах) гэх мэт олон янзаар мөлхдөг байна. Түүнчлэн огт мөлхдөггүй, юм түшин зогсож сураад шууд хөлд ордог хүүхэд ч бий. Огт мөлхөөгүй мөртлөө юм түшиж зогсоод, дамжиж алхдаг болсон бол санаа зовох хэрэггүй.

Хүүхэд 18 сар хүрсэн ч мөлхөхгүй байвал, сэрүүн үедээ ямар байрлалтай байх дуртай, хэрхэн тоглодог талаар эцэг эхээс нь асуух шаардлагатай. Эргэж хөрвөөх, суух, түрүүлгээ харах байрлал нь тогтворгүй, 2 суганаас нь барьж зогсооход цогих хөдөлгөөн хийдэггүй, ерөнхийдөө булчин сул, эсвэл хэт чангарсан байдал илэрвэл, мэдрэлийн эмчид хандахыг зөвлөнө.

Нөгөө талаар, хүүхдийн жижиг хашлага, хашлагатай оронд байнга байлгадаг, олон янзын тавилгатай давчуу өрөө, эсвэл шалан дээр элдвийн зүйл хөглөрсөн орчинд байлгадаг бол, хүүхэд биеэ чөлөөтэй хөдөлгөн дуртай зүг рүүгээ байрлалаа өөрчлөн шилжих боломжтой, аюулгүй орон зай бүрдүүлж өгөх нь зүйтэй. Мөн том хүн ойр байж, хүүхдийн сониуч занг хөдөлгөх тоглоом харуулан дуудаж хүүхдийн өөрөө мөлхөж урагшлах хүслийг төрүүлэх, хөлөөс нь бариад хөдөлгөөнийг нь дагуулан алгуур дэмжих зэргээр өөрөө урагшилж чадаж буй мэт мэдрэмжийг хүүхдэд төрүүлж өгч болно. Хүүхэд өөрөө урагшилж хөдлөхийг хүсэж л байвал, ямар байдлаар мөлхөх нь чухал биш байдаг. Гол нь хүүхэд өөртөө зугаатайгаар, биеэ аль болох их хөдөлгөж, хөлд ороход хэрэгтэй булчин шөрмөс, тамир тэнхээ, хөдөлгөөн хязгаарлах чадвар суух нь чухал.



*Зугаацаж тоглонгоо бүх биеэ хөдөлгөх нь чухал.*



*Тоглоом ашиглан хүүхдэд хөдлөх сэдэл, хүсэл төрүүлэх.*

Зарим хүүхэд юм түшиж зогсдог, дамжиж явдаг, эсвэл түшихгүйгээр зогсож сурдаг боловч, өөрөө алхахгүй хаширладаг. Хэрэв нэг гараас нь дэмжээд өгөхөд алхаж чадахаар байвал, хүүхэд өөрөө зоригтой алхаж сурах хүртэл нь том хүн хамт аль болох их алхуулж, алхах үед хөлийн уланд ирэх мэдрэмжид дасган тэнцвэрээ олж сургах хэрэгтэй. Мөн өөрөө чадан ядан алхсанаас мөлхөх нь аюулгүй, илүү түргэн очих газартаа хүрдэг тул 18 сартай хүүхэд хэдийд алхаж, хэдийд мөлхөх вэ гэдгээ сайн ялган өөрөө явж орчинтойгоо танилцдаг. Харин хүүхдээ хөлд оруулах гэж байна гээд мөлхөхийг нь хорихгүй байхыг зөвлөх нь зүйтэй.

## **Асуулт 2: Манай хүүхэд их уйлдаг**

Үгээр сэтгэл санаагаа илэрхийлж чадахгүй, хөлд ороогүй хүүхдийн хувьд сэтгэл санаагаа болон хүсэж буй зүйлээ хэн нэгэнд дамжуулах илэрхийллийн арга нь уйлах юм. Нярай хүүхэд өлсөх, эсвэл бие нь таагүй санагдвал уйлдаг. 3-6 сартай хүүхэд хөхөө хөхөх, тэврүүлэхийг хүсэж байгаагаа уйлж илэрхийлэх бөгөөд томрох тусам эрхлэх, ээжийгээ дагах, бишүүрхэж гэрэвших, тавгүйрхэх, цухалдах зэрэг олон шалтгаанаар уйлдаг болно. Хүүхэд уйлах нь том хүмүүст

хэцүү санагддаг ч, хүүхдийн хөгжлийн хувьд “Хэл ярианы өмнөх хэл яриа” нь бөгөөд чухал ач холбогдолтой гэдгийг эцэг эхчүүдэд тайлбарлаж ойлгуулах хэрэгтэй.

Хэт их уйлаад байдагт нь санаа зовдог эцэг эхэд, ямар үед уйлдаг вэ, уйлах шалтгааныг нь (Хүүхдийн сэтгэл санаа) эцэг эх нь ойлгодог уу, ямар арга хэмжээ авахад уйлахаа больдог вэ, ой хүрэхээс өмнөхтэй нь харьцуулахад өөрчлөгдсөн зүйл байгаа юу гэх мэтчилэн асууж тодруулна. Түүнчлэн хүүхэд уйлахад эцэг эхэд нь ямар асуудал хүндрэл үүсдэг, эцэг эх нь хэрхэн хүлээн авдаг болон хүүхэд өсгөхөд гардаг стресс ямар байгаа талаар мэдэж авах шаардлагатай.

Ой хүрэхэд “Бусдад өөрийгөө илэрхийлэх” чадвар нь нахиалж эхлэх бөгөөд 18 сартайгаас 2 нас 6 сар хүртэл ихэнх хүүхдийн “Дуулгаваргүй үе” нь оргилдоо хүрнэ. Энэ үед нь том хүн хүссэнийг нь биелүүлж өгөхгүй байх, эсвэл хийхийг хүссэнийг нь хориглож болиулахад ихэд дургүйцэн чанга уйлдаг. Ингэж уйлахад, намайг уйлбал хүссэнийг нь минь биелүүлж өгнө гэж горьдох болон өөрийгөө хянаж чадахгүйн улмаас цухалдаж уйлах гэсэн 2 тохиолдол байж болно. Эхнийх нь, уйлбал миний санаснаар болно гэсэн бодлыг олон удаа төрүүлсний улмаас зуршил болсон байж болно гэж ойлгох үндэслэлтэй учраас жирийн үед хүүхэдтэйгээ харьцдаг байдлаа өөрчлөх шаардлагатай. Мөн цухалдаж уйлсан тохиолдолд, эцэг эх нь хүүхдийнхээ уур бухимдал, бууж өгөхгүй байгаа байдлыг нь ойлгон эвтэйхэн тэвэрч аргадах, эсвэл өөр тоглоом тоглох эсэхийг нь асуух, өөр зүйлд анхаарлыг нь хандуулах зэргээр аргалж, өөрийгөө хянахад сургахын чухлыг эцэг эхэд нь хэлж өгнө. Хүүхдийн хэл ярианы чадвар хөгжөөд ирвэл уйлах нь аяндаа багасаж, өөрийгөө илэрхийлж чаддаг болно.

Нөгөөтэйгүүр, унтахаасаа өмнө тогтмол цагт заавал уйлдаг, гэнэт орилж уйлдаг зэргээр үл ойлгогдохуйцаар уйлаад байдаг бол, бие нь тавгүйтсэн, эсвэл өвчин эмгэг, гэмтэл бэртлээс улбаатай өвдөлтийн шалтгаан ч байж болзошгүй. Мөн нойрны хэмнэл тогтворгүй, хангалттай нойр авч чадаагүй хүүхэд өдөртөө аашилж уйлах нь элбэг тохиолддог. Харшилтай болон хэт мэдрэмтгий хүүхэд дуу чимээ болон гэрэл, агаарын хэм, чийгшил, хувцасны даавуу зэргээс тавгүйцэж уйлах тохиолдол ч бий. Хүүхдийн тавгүй байдалд эцэг эхийн анзаараагүй ямар нэг нөхцөл шалтгаан байгаа эсэхийг ч нарийн асууж тодруулах нь чухал байдаг.

### **Асуулт 3: Манай хүү/охин хэлд орохгүй байна.**

18 сартай хүүхдийн хэл ярианы хөгжил нилээд харилцан адилгүй ч, ихэнх хүүхэд утгатай үг 2-ыг хэлж сурсан байдаг. Энэ насанд утгатай үг хэлэхгүй байвал дараах зүйлүүдийг шалгана.


- (1) Сонсголын асуудалтай эсэх. Нэрээр нь дуудахад эргэж хардаг уу, дуртай дуу байгаа юу, дургүй дуу чимээ байдаг уу, зурагтад чихээ ойртуулж сонсдог уу гэдгийг эцэг эхээс нь асууна.
- (2) Том хүнтэй хамт ямар нэг тоглоом тоглох, том хүн хуруугаар заахад хариу үйлдэл үзүүлэх, хүссэн зүйлээ хуруугаар зааж том хүнд харуулах гэсэн 3 талт холбоо хамаарал болон хамт анхаарч буй байдал, эцэг эхдээ эрхэлж наалдах үйлдэл (Эрхлэх, бишүүрхэх, дагах г.м) ажиглагдах эсэхийг шалгана.
- (3) Хүн дуурайж дуугарах, хүний хөдөлгөөнийг дуурайн гарын хөдөлгөөн оролцсон дуу дуулах, модон шоогоор орлуулж тоглох, айл гэр болж тоглох болон хүүхэддэйгээр тоглох, ахуйн хэрэглээний зүйлийг томчуудыг дуурайж хэрэглэхийг хүсэх байдал ажиглагдах эсэхийг тодруулна.

(1)-(3)-г хамаарах хөгжлийн асуудал байхгүй бол, өдөр тутамд хүүхэдтэй харилцах арга барилаа эргэн харах замаар адгаж яаралгүйгээр хүүхдийнхээ хэл ярианы хөгжлийг анхааралтай ажиглахад болно гэдгийг хэлж өгнө. Боломжтой бол эцэг эхтэй нь тогтмол уулзаж ярилцах, эх хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцуулах зэргээр дэмжлэгээ үргэлжлүүлэх нь зүйтэй. Өдөр тутамд хүүхэдтэй хэрхэн ажиллах тухай зөвлөхдөө дараах зүйлүүдэд анхаарч, айл бүрийн нөхцөл байдалд тохируулан эцэг эх нь хүүхэдтэйгээ хамт хийж гүйцэтгэх боломжтой зүйлээс эхлүүлэхийг зөвлөвөл зохино. Гэхдээ хүүхэддээ үг цээжлүүлэх гэж шавдуулах, эсвэл хүүхдийн буруу хэлсэн авиа дуудлагыг засах гэж оролдох нь хүүхдийн ярих хүсэлд саад болж, эсрэг үр дүнд хүрч болохыг тайлбарлана.

- Хооллох, живх солих, усанд оруулах, унтуулах зэргээр эцэг эх нь өдөр бүр хүүхдээ асрах явцад, хүүхдээр үйлдэл хийлгэхтэй зэрэгцэн аль болох их ярьж байх нь зүйтэй. Жишээлбэл, хоолыг нь идүүлэхдээ "... идье. Амаа аан гээд том ангайгаарай", "... ямар гоё амттай юм бэ", "Хоолоо сайн иддэг мундаг хүүхэд шүү", "Аягандаа хоолоо үлдээхгүй идсэн байна", "Яасан амттай юм бэ" гэх зэргээр хүүхэдтэйгээ ярих боломжтой үе олон байдаг. Ялангуяа авиа дуурайсан үг, аялга үг нь хүүхдийн хувьд дуурайж хэлэхэд амархан, утгатайгаа холбож ойлгоход ч дөхөм байдаг. Мөн хүүхдийн сэтгэл санааг төлөөлөн өмнөөс нь ярьж өгөх нь хэл ярианы хөгжилд үр дүнтэй байдаг.
- Үргэлж тоглодог тоглоомоороо тоглож байх үед нь тогтмол нэг үг хэлж хүүхдэд сонсох, яг эгзэгийг нь олж хэлэх зэргээр сонирхолтой болгож болно. Жишээлбэл, "Хаана байна, энэ байна" гэж давтах, "Энэ байна" гэхдээ аль болох хүүхдээр хэлүүлж дуугаргахыг оролдох, эсвэл нэрийг дуудахад "За" гэж гараа өргөн хариулж тоглох, өөд өөдөөсөө харж суугаад бөмбөгөөр

харилцаж тоглохдоо “Надад өгөөрэй”, “Заа май”, “Баярлалаа” гэх зэрэг харилцаа үг аль болох олон хэлж сонсгох нь зүйтэй.

- Хүүхэд ямар нэг юм авчраад хуруугаараа зааж харуулаад байвал, хэлэх үгийг нь өмнөөс нь хэлэх, өөр үгээр баяжуулан хэлж өгч болно. Жишээлбэл, хүүхэд нисч байгаа онгоц олж хараад хуруугаараа зааж, эсвэл ямар нэг авиа хэлбэл, “Хөөх онгоц нисч байна. Үү-үүн гэж дуугарч байна, тийм үү. Хаашаа нисэж байгаа юм бол. Сууж үзэх юмсаан” гэх зэргээр хүүхэдтэйгээ сайн ярих хэрэгтэй.
- Зурагтай ном үзэх дуртай хүүхэд байвал, хуруугаараа заасан зураг дээрх зүйлийн нэрийг нь хэлж өгөх, хуруугаараа зааж хэлж өгөх нь зүйтэй. Зурагтай номын зургийг огт сонирхохгүй байвал албадах шаардлагагүй.
- Хүүхдээ саатуулахдаа зөвхөн зурагтын нэвтрүүлэг, дүрс бичлэг харуулаад орхих бус, болж өгвөл хамт үзэнгээ дууг нь дуулж, хүүхэдтэйгээ ярих гэж оролдох нь зүйтэй.



*Хүүхдийнхээ илэрхийлэх гэсэн санааг өмнөөс нь үгээр хэлж өгөх*



*Зурагт ном хамтдаа үзэх*

# **ХАВСРАЛТ 1.**

---

18 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн  
цогц үзлэгийн маягт



## 18 САРТАЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ЦОГЦ ҮЗЛЭГИЙН МАЯГТ

### ХҮҮХДИЙН МЭДЭЭЛЭЛ

				Регистрийн дугаар:
Хүүхдийн ургийн овог:				Хүйс: Эр / Эм Хүүхдийн хүйсийг заавал дугуйлан тэмдэглэ!
Эцэг, эхийн нэр:				Хот, аймаг, дүүрэг      Сум, хороо      Баг, хэсэг
Хүүхдийн нэр:				Гэрийн хаяг: Утасны дугаар: 1. 2.
Төрсөн он	сар	өдөр	Цаг	Хүүхдийн нас: ____ сар ____ хоногтой

### ЭХИЙН МЭДЭЭЛЭЛ

Регистрийн дугаар:

Эцэг, эхийн нэр:		Хот, аймаг, дүүрэг	Сум, хороо	Баг, хэсэг
Нэр:				
Яс үндэс:		Ажлын газар, эрхэлдэг ажил, утас:		
Мэргэжил:	Боловсрол:	Гэр бүлийн байдал:	Ам бүлийн тоо:	
Амьдралын нөхцөл байдал	<input type="checkbox"/> Амины сууц <input type="checkbox"/> Орон сууцны байранд <input type="checkbox"/> Гэрт <input type="checkbox"/> Бусад амьдардаг			
Хэнтэй амьдардаг вэ?	Хүүхэд (Тоо: ____), <input type="checkbox"/> Нөхөр, <input type="checkbox"/> Хадам аав, <input type="checkbox"/> Хадам ээж <input type="checkbox"/> Өөрийн аав, <input type="checkbox"/> Өөрийн ээж, <input type="checkbox"/> Бусад (тоо: ____ )			
Тамхи татдаг уу? <input type="checkbox"/> Тийм (өдөрт _____ тамхи татдаг) <input type="checkbox"/> Үгүй				
Архи хэрэглэдэг үү? <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Хааяа				

### ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Дараах өвчнөөр өвчилж байсан уу?  гэж тэмдэглэнэ.

Цусны даралт ихсэх,    Бөөрний архаг үрэвсэл,    Чихрийн шижин,

Зүрх, үе мөчний өвчин,    Бамбай булчирхайн өвчин,    Харшил

Бусад өвчин (нэрлэнэ үү)

.....

Дараах халдварт өвчнөөр өвчилж байсан уу?

Улаанууд  Тийм \_\_\_\_\_ нас  Үгүй  Вакцин хийлгэсэн

Улаанбурхан  Тийм \_\_\_\_\_ нас  Үгүй  Вакцин хийлгэсэн

Салхин цэцэг  Тийм \_\_\_\_\_ нас  Үгүй

Халдварт гепатит  Тийм \_\_\_\_\_ нас  Үгүй  Вакцин хийлгэсэн

Мэс засал хийлгэж байсан уу?  Тийм бол  Үгүй

Ямар: .....

Нөхрийн эрүүл мэнд:  Хэвийн  Хэвийн биш

(Өвчин юм уу зовуурь: .....) )

Цусны бүлэг: Эх  0 I  A II  B III  AB IV  Мэдэхгүй

Эцэг  0 I  A II  B III  AB IV  Мэдэхгүй

### ЭХИЙН ЖИРЭМСЛЭЛТИЙН ТҮҮХ

Хэдэн удаа жирэмсэлсэн.....

Бага жинтэй хүүхэд төрүүлж байсан уу (22-36 долоо хоног)

Тийм бол ..... удаа  Үгүй

Үр хөндүүлж байсан эсэх

Тийм бол ..... удаа  Үгүй

Зулбаж байсан уу?

Тийм бол ..... удаа  Үгүй

Хэдэн удаа төрсөн.....

Одоо хэдэн хүүхэдтэй.....

Энэ хүүхдийн өмнөх жирэмслэлтийн .....он

ХҮҮХДИЙН ТӨРӨЛТИЙН ТҮҮХ

- Хэд дэх хүүхэд .....
- Төрөх үеийн хүүхдийн жин/урт (кг/см) .....
- Төрөлтийн явц  хэвийн  бүтэлтгэй  кесар  Бусад .....
- Төрөхөд тандалт шинжилгээ хийсэн үү?  сонсгол  нүд  түнх  
 зүрх  бодисын солилцооны (өсгийнөөс цус авч)  
 бусад.....
- Төрөнгүүт уйлсан уу?  тийм  үгүй
- Төрөнгүүт амлуулсан уу?  тийм  үгүй
- Төрөнгүүт хүүхдийг ээжийнх нь цээжин дээр тавьсан уу?  тийм  үгүй

Өмнөх өвчлөлийн талаарх мэдээлэл √ тэмдэглэнэ.

- Улаанбурхан  Салхин цэцэг  Улаанууд  Гахай хавдар
- Менингит  Халдварт гепатит  Гар хөл амны өвчин
- Бусад .....

18 САРТАЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

(Үзлэгийг 20\_\_ оны \_\_ сарын \_\_ нд хүүхэд \_\_ сар \_\_ хоногтой байхад хийв).

(Хүүхдэд илэрсэн шинж бүрд √ гэж тэмдэглэнэ)

Жин (кг)..... Урт, өндөр (см)..... ЖН-ны Z оноо..... ЖУ-ын Z оноо..... УН-ны Z оноо.....	Толгойн тойрог (см): ..... Толгой хэмжээ: <input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> Том <input type="checkbox"/> Жижиг
Хооллолт: <input type="checkbox"/> Хөхөө хөхдөг <input type="checkbox"/> Угждаг <input type="checkbox"/> Нэмэгдэл хоол иддэг Өдөрт .....удаа, нэг удаад ..... мл иддэг Хоолны нэр төрөл: 1.....2.....3.....4.....	

<p>Арьс, үс, хумс:</p> <p><input type="checkbox"/> Хэвийн,      <input type="checkbox"/> Хэвийн бус бол: (√ гэж тэмдэглэ)</p> <p><input type="checkbox"/> Арьсны уян чанар алдагдсан <input type="checkbox"/> Шарлалт <input type="checkbox"/> Тууралт</p> <p><input type="checkbox"/> Атопи (Шүүдэст эмзэгшил) <input type="checkbox"/> Хөлийн тавхайн хаван <input type="checkbox"/> Илт тураал</p> <p><input type="checkbox"/> Нуралт    <input type="checkbox"/> Үрэвсэл    <input type="checkbox"/> Хумс хөх</p> <p><input type="checkbox"/> Алганы зураасны өөрчлөлт    <input type="checkbox"/> Мөөгөнцөр    <input type="checkbox"/> Бусад _____</p>
<p>Цус багадалтын шинж:</p> <p><input type="checkbox"/> Илрээгүй    <input type="checkbox"/> Алга цайсан    <input type="checkbox"/> Хувхай цагаан</p>
<p>Толгой, хүзүү, захын тунгалгийн булчирхай:</p> <p><input type="checkbox"/> Хэвийн              <input type="checkbox"/> Хэвийн бус: (√ гэж тэмдэглэ)</p> <p><input type="checkbox"/> Макроцефали    <input type="checkbox"/> Микроцефали    <input type="checkbox"/> Гидроцефали    <input type="checkbox"/> Толгойгоо даахгүй</p> <p><input type="checkbox"/> Хүзүү гилжгий    <input type="checkbox"/> Тунгалгийн булчирхай томорсон, хөндүүр</p> <p><input type="checkbox"/> Бусад _____</p>
<p>Яс, булчингийн тогтолцоо:</p> <p><input type="checkbox"/> Хэвийн    <input type="checkbox"/> Хэвийн бус бол: (√ гэж тэмдэглэ)</p> <p><input type="checkbox"/> “Шувуун цээж” шинж    <input type="checkbox"/> Нуруу муруй    <input type="checkbox"/> “Сампингийн эрхи” шинж</p> <p><input type="checkbox"/> Дагз зөөлрөх    <input type="checkbox"/> Түнхний эмгэг    <input type="checkbox"/> Шилбэ муруй</p> <p><input type="checkbox"/> Үе мөчдийн хөдөлгөөн хязгаарлагдсан</p> <p><input type="checkbox"/> Үений үрэвсэл              <input type="checkbox"/> Булчингийн хатангиршил    <input type="checkbox"/></p> <p>Бусад _____</p> <p>Булчингийн хүчдэл: <input type="checkbox"/> Хэвийн    <input type="checkbox"/> Хэт ихэссэн    <input type="checkbox"/> Сул</p>
<p>Нүд:</p> <p><input type="checkbox"/> Хэвийн    <input type="checkbox"/> Хэвийн бус: (√ гэж тэмдэглэ)</p> <p><input type="checkbox"/> Хялар    <input type="checkbox"/> Харааны бэрхшээл    <input type="checkbox"/> Урвасан зовхи    <input type="checkbox"/> Харц эгцэлж харахгүй</p> <p><input type="checkbox"/> Гэрэлд хэт мэдрэг    <input type="checkbox"/> Бусад _____</p>
<p>Чих, хамар, хоолой:</p> <p><input type="checkbox"/> Хэвийн    <input type="checkbox"/> Хэвийн бус бол: (√ гэж тэмдэглэ)</p> <p><input type="checkbox"/> Хамрын эмгэг    <input type="checkbox"/> Аденоидит    <input type="checkbox"/> Гүйлсэн булчирхай</p> <p><input type="checkbox"/> Чихнээс булаг гарсан: .....хоног</p> <p><input type="checkbox"/> Бусад _____</p> <p>Сонсгол: <input type="checkbox"/> Хэвийн    <input type="checkbox"/> Хэвийн бус _____</p>

<p>Амьсгалын тогтолцоо:</p> <p><input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> Хэвийн бус бол: (<math>\sqrt{\quad}</math> гэж тэмдэглэ)</p> <p><input type="checkbox"/> 14-өөс олон хоног ханиалгасан <input type="checkbox"/> Амьсгал 1 минутад 40-өөс олширсон</p> <p><input type="checkbox"/> Цээж хонхолзсон <input type="checkbox"/> Шуугиантай амьсгал <input type="checkbox"/> Хяхтнаа амьсгал</p> <p><input type="checkbox"/> Хэржигнүүр <input type="checkbox"/> Бусад _____</p>
<p>Зүрх судасны тогтолцоо:</p> <p><input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> Хэвийн бус бол: (<math>\sqrt{\quad}</math> гэж тэмдэглэ) Зүрхний цохилтын тоо.....</p> <p><input type="checkbox"/> Тахикарди <input type="checkbox"/> Брадикарди <input type="checkbox"/> Авиа бүдэг</p> <p><input type="checkbox"/> Хэм алдагдалтай <input type="checkbox"/> Шуугиантай <input type="checkbox"/> Бусад _____</p>
<p>Хоол боловсруулах тогтолцоо:</p> <p><input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> Хэвийн бус бол: (<math>\sqrt{\quad}</math> гэж тэмдэглэ)</p> <p><input type="checkbox"/> Бөөлждөг <input type="checkbox"/> Хэвлий эмзэглэлтэй</p> <p>Элэг: <input type="checkbox"/> Том <input type="checkbox"/> Эмзэглэлтэй <input type="checkbox"/> Дэлүү том</p> <p><input type="checkbox"/> Суулгалт <input type="checkbox"/> Баас хатдаг <input type="checkbox"/> Хүйний ивэрхий <input type="checkbox"/></p> <p>Бусад _____</p>
<p>Шээс бэлгийн тогтолцоо:</p> <p><input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> Хэвийн бус бол: (<math>\sqrt{\quad}</math> гэж тэмдэглэ)</p> <p><input type="checkbox"/> Орондоо шээдэг <input type="checkbox"/> Шөнө бүр шээдэг <input type="checkbox"/> Дүлж шээдэг</p> <p><input type="checkbox"/> Төмсөг усжилттай <input type="checkbox"/> Төмсөг хуухнагт буугаагүй</p> <p><input type="checkbox"/> Тээрхийн арьс чөлөөтэй эргэхгүй</p> <p><input type="checkbox"/> Цавины ивэрхий <input type="checkbox"/> Бусад _____</p>
<p>Мэдрэлийн эрхтэн тогтолцоо:</p> <p><input type="checkbox"/> Хэвийн <input type="checkbox"/> Хэвийн бус бол: (<math>\sqrt{\quad}</math> гэж тэмдэглэ)</p> <p><input type="checkbox"/> Дагз хөшингө <input type="checkbox"/> Саажилттай _____</p> <p><input type="checkbox"/> Эмгэг рефлексүүд илэрсэн</p> <p><input type="checkbox"/> Татдаг _____ <input type="checkbox"/> Бусад _____</p>

Нүдэнд ил харагдах хөгжлийн эмгэг:

- Үгүй  Эмгэгтэй бол: (✓ гэж тэмдэглэ)
- Уруул тагнайн сэтэрхий  Чихний дэлбэнгүй
- Чихний гадна суваггүй  2 нүдний зай хол  Хөлгүй
- Гаргүй  Олон хуруу  Цөөн хуруу
- Бусад \_\_\_\_\_

Амны хөндий:

- Хүүхдийн шүд анх \_\_\_\_\_ сартайдаа ургасан.
- Одоо байгаа шүдний тоо \_\_\_\_\_
- Шүдний цагаан толбо  Шүдний өнгө өөрчлөгдсөн
- Шүдний ургалт буруу  Буйлны үрэвсэл  Хэл мурийсан
- Хэлний хөвч богино  Бусад \_\_\_\_\_

	Доод эрүү	Ургалт	Солигдох
	2 дахь бага араа	23-31 сар	10-12 нас
	Эхний бага араа	14-18 сар	9-11 нас
	Соёо	17-23 сар	9-12 нас
	Доод үүдэн хажуу	10-16 сар	7-8 нас
	Доод үүдэн	6-10 сар	6-7 нас

Цоорсон, эмчилгээ хийгдээгүй шүдийг зурагт (X) гэж тэмдэглэнэ үү.

**Сүүн шүдний зураг**

	Дээд эрүү	Ургалт	Солигдох
	Дээд үүдэн	8-12 сар	6-7 нас
	Дээд үүдэн хажуу	9-13 сар	7-8 нас
	Соёо	16-22 сар	10-12 нас
	Эхний бага араа	13-19 сар	9-11 нас
	2 дахь бага араа	25-33 сар	10-12 нас

- Эмчилгээ шаардлагатай (Шүдний тоо \_\_\_\_\_)

## ДАРХЛААЖУУЛАЛТ

Товлол	Вакцинууд	Хийсэн огноо/сери
Төрснөөс хойш 24 цагийн дотор	БЦЖ (Сүрьеэгийн эсрэг вакцин) (BCG)	
	Халдварт саагийн эсрэг вакцин (Polio)	
	В Гепатитын эсрэг вакцин (Нер В)	
2-4 сартайд	Халдварт саагийн эсрэг вакцин (Polio)	
	Тавт вакцин (Сахуу, хөхүүл ханиад, татран, +В Гепатит, хемофилюс инфлюенза В) (Penta)	
	Пиевмококкийн эсрэг вакцин (PCV)	
5 сартайд	Халдварт саагийн эсрэг вакцин (Polio)	
9 сартайд	УГУ вакцин (Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг) (MMR)	
	Пиевмококкийн эсрэг вакцин (PCV)	
1 нас 2 (24 сар) сартайд	А Гепатитын эсрэг вакцин (Нер А)	
Бусад		

Дархлаажуулалтад бүрэн хамрагдсан эсэх:  Тийм  Үгүй

Хүүхдийн хөгжлийг үнэлэхэд шаардлагатай аяга, зурагтай ном, ус зэргийг бэлтгэнэ.

Хүүхдийн хөгжлийн үзүүлэлт	Тэмдэглэсэн
Хүүхэд өөрөө сайн явж чадаж байна уу? ( __ нас __ сартайдаа хөлд орсон)	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Хүүхэд утгатай, тухайлбал “ээж”, “аав” гэх мэт үг хэлж байна уу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Аяганаас өөрөө ууж чадаж байна уу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Хүүхэд угжаар уусаар байна уу? (шүд цоорохоос сэргийлэх зорилгоор угжаар уухыг зогсоох хэрэгтэй)	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Хүүхэд цагаар хооллодог уу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Хүүхдийн нүд нь ер бусын хөдлөх эсвэл гэрэлд хэт их мэдрэмтгий байдаг уу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Хүүхэд хүний нүд рүү эгцэлж харж чадаж байна уу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Хүүхдийг араас нь нэрээр нь дуудахад эргэж хардаг уу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Хүүхдэд шүдээ угаахыг зааж өгөхөд дууриаж угааж чаддаг уу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Таны хүүхэд юу хийх, оролдох дуртай вэ? Жишээ нь: .....	
Хүүхдээс мэддэг юмыг нь асуухад хуруугаараа зааж чадаж байна уу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй

Өөрийн биеийн эрхтнүүдийг мэддэг үү? Тухайлбал амаа ангай, хэлээ гарга гэх мэт	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Хүүхэдтэй хамт байхдаа тэдэнтэй хамтдаа тоглодог уу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Танил хүмүүстэйгээ ярилцах дургтай юу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Тэврэхэд хариуд нь бас тэвэрнэ.	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Өөртэй нь тоглоход инээнэ, ход ход инээнэ.	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй

Тусгай тэмдэглэл: Асран хамгаалагчийн санал болон нэмэлт тэмдэглэл \_\_\_\_

### ОНОШ/ҮНЭЛГЭЭ БА ЭХ, ХҮҮХДЭД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

#### 1. Хоол тэжээлийн талаар онош/үнэлгээ

Зөвлөмж

\_\_\_\_\_

#### 2. Эрүүл мэндийн талаар онош/үнэлгээ

\_\_\_\_\_ Зөвлөмж

#### 3. Хөгжлийн онош/үнэлгээ

\_\_\_\_\_ Зөвлөмж

Явцын хяналт, ажиглалт

\_\_\_\_\_

Төрөлжсөн мэргэжлийн зөвлөгөө \_\_\_\_\_

Эрүүл мэндийн дэлгэрэнгүй шинжилгээ \_\_\_\_\_

Илгээсэн байгууллага, газар \_\_\_\_\_

Үзлэг хийсэн байгууллага: \_\_\_\_\_

Эмчийн нэр: \_\_\_\_\_



## **ХАВСРАЛТ 2.**

---

Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн ээлжит үзлэгт дэмжлэгт хяналт хийх удирдамж

## ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ЭЭЛЖИТ ҮЗЛЭГТ ДЭМЖЛЭГТ ХЯНАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

Энэхүү дэмжлэгт хяналтыг хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн үед хийнэ. Ингэхдээ 18 сартай хүүхдийн үзлэг хийх сургалтад хамрагдсанаас хойш наанадаж нэг сарын хугацаанд хийвэл тохиромжтой. Дэмжлэгт хяналтын багт АЭМГ, ДЭМТ-өөс энэ үзлэгийн талаар мэдлэг ойлголттой ажилтнууд, эмчилгээний чанарын алба болон бусад сургагдсан эмч ажилтнуудаас бүрдсэн байна.


### Дэмжлэгт хяналтын зорилго:

Дэмжлэгт хяналт нь хүүхдийн эрүүл мэнд хөгжлийн цогц үзлэгийн чанарыг сайжруулах зорилготой. Ингэхдээ:

- ӨЭМТ, СЭМТ-ийн эмч нарт хүүхдийн эрүүл мэндийн үзлэг хийхэд нь туслах,
- ӨЭМТ, СЭМТ-ийн эмч нарыг үзлэг хийх явцад гардаг асуудал бэрхшээлийг олж мэдэх,
- ӨЭМТ, СЭМТ-ийн эмч нарын үзлэг хийж буй үйлдлийг ажиглаж мэдээлэл цуглуулах ба үзлэг хийхэд бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэх зэрэг хүрээг хамарна.

### Дэмжлэгт хяналтын тухай ойлголт:

Дэмжлэгт хяналт нь ӨЭМТ, СЭМТ-ийн эмч нарын ур чадварыг сайжруулах, үзлэг хийхэд гарч буй бэрхшээлийг илрүүлэн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хэд хэдэн үйл ажиллагаанаас бүрдэнэ. Үйл ажиллагаануудыг дараах бүдүүвчид харуулав.



<sup>2</sup> Эрүүл мэндийн байгууллага: Тухайн ӨЭМТ, СЭМТ болон аймгийн ЭМГ, дүүргийн ЭМТ.

**1. Дэмжлэгт хяналт хийх талаар танилцуулах**

Хяналт хийх багийн гишүүд нь тухайн ӨЭМТ, СЭМТ-д хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийг ажиглахаар ирсэн тухайгаа танилцуулна. Ингэхдээ энэ дэмжлэгт хяналт нь үзлэг хийх эмч нарт туслах зорилготой гэдгийг ойлгуулна

**2. Үзлэг хийж байгааг ажиглах, ур чадвараа сайжруулах, ажиглалтад үндэслэн мэдээлэл цуглуулах**

Хянагчид нь,

- 1) Эмч нарын үзлэг хийж байгааг ажиглах ба тэдний ур чадвар нь сайжирч байгаа эсэхийг судална. Ингэхдээ үзлэгийн маягт болон энэхүү гарын авлагыг ашиглана.
- 2) Үзлэгт хүүхдээ авч ирсэн асран хамгаалагчдаас үзлэгийн талаарх сэтгэгдэл болон эмчийн өгсөн зөвлөгөө, хүүхдээ өсгөж бойжуулахад тулгарч буй асуудлуудын талаар асууна.
3. **Үзлэгийн явцад гарсан бэрхшээлүүд, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар эмч, сувилагч нартай ярилцах**

Үзлэгийн явцад гарсан бэрхшээлүүдийг эмч нартай ярилцаж үзлэгийг ажиглах явцад цуглуулсан мэдээллээ танилцуулж, үзлэг зохион байгуулахад байгууллагын зүгээс үзүүлэх дэмжлэгийг хэлэлцэнэ. Мөн үзлэгийг тогтмол явуулах, хүүхдийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах талаар ярилцана. Жишээ нь үзлэг хийх өрөө тасалгаа, эмч нарын хуваарь, хүүхдүүдийн нэрсийн жагсаалт, үзлэгийн маягт, багцын жин, хүүхдийн хөгжлийг үнэлэх тоглоом, зураг зэрэг үзлэг хийх бэлтгэл хангагдсан эсэхийг үзнэ.

**4. Эрүүл мэндийн байгууллагын удирдлагад танилцуулж цаашдын төлөвлөгөөг ярилцаж тайланг бичгээр өгнө.**

Хянагчид нь өөрсдийн цуглуулсан мэдээллийг нэгтгэж тухайн ӨЭМТ, СЭМТ-ийн удирдлагад танилцуулж, тус байгууллагад үзлэг хийхэд шаардлагатай зай, өрөө тасалгаа, жин, өндөр хэмжигч, үзлэгийн маягтууд, хүүхдийн хөгжлийг үнэлэх тоглоом, зурагтай ном, аяга зэрэг хангалттай байгаа эсэхийг танилцуулж цаашид үзлэгийг хэрхэн чанартай болгох төлөвлөгөөг хэлэлцэнэ.

**Дэмжлэгт хяналт хийх үйл явц:**

**1) Бэлтгэл ажил**

- Дэмжлэгт хяналтын багийн гишүүдийг сонгоно.
- Очих байгууллагын өмнөх саруудын үзлэгийн тайлангуудаас гарч байсан асуудлуудыг нэгтгэн дүгнэсэн байна.

- Дэмжлэгт хяналт хийх хянагчдад шаардлагатай хэрэгслүүд:

- Үзэг харандаа, баллуур
- Хавчаар бүхий гар самбар
- Үзлэгийн ашиглаагүй маягт

- Дэмжлэгт хяналт хийх шалгах хуудас

2) **ӨЭМТ, СЭМТ-д дэмжлэгт хяналт хийх талаар танилцуулах:**

- ӨЭМТ, СЭМТ-д очиж зорилгоо танилцуулж, ажиглах эмчээ мэдэж авна. (тухайн эмч хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн сургалтад хамрагдаагүй байсан ч болно)
- Үзлэг хийхтэй холбоотойгоор бусад холбогдох ажилтнуудтай товчхон танилцаж, юу хийх талаараа тайлбарлана.
- Өмнөх үзлэгүүдээс гарч байсан асуудлын талаар ярилцана.
- Үзлэг хийх байр, орон зай, зохион байгууллалтын талаар ойлголттой болно.
- Холоос ажиглах тохиромжтой суудлыг тогтооно.

3) **Үзлэг хийж буйг ажиглах, үзлэгт ирсэн хүүхдийн асран хамгаалагчтай ярилцах**

- Үзлэгт уригдсан 18 сартай 2 хүүхдийг сонгоно.
- ӨЭМТ, СЭМТ-ийн эмчийн хүүхдэд үзлэг хийж байгааг ажиглана.
- Ажиглахдаа өөрт байгаа үзлэгийн маягт дээрээ зэрэг тэмдэглээд явна.
- Хүүхдийг үзэж эхэлсэн цаг минут, дууссан цаг минутыг тэмдэглэнэ.
- Асран хамгаалагчтай ярилцлага хийнэ.
- Шалгах хуудсанд тэмдэглэгээ хийнэ.
- Үзлэг хийсэн эмчийн сайн талыг хэлж урамшуулна.
- Хэрэв буруу зүйл хийсэн бол зөвхөн өөрт нь хэлж зааж өгнө.
- Эмч сургалтад хамрагдаагүй, эсвэл алдаа их гаргаж байвал дараагийн хүүхдийг хамтдаа үзэж болно.
- Үзлэгийн явцад зөвлөгөө өгч байгааг сайтар ажиглаж үзлэгийн дараа зөв бурууг эмчид зааварлаж өгнө.

4) **ӨЭМТ, СЭМТ-ийн хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг зохион байгуулах чадавхыг ажиглах**

Эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийхэд тухайн ӨЭМТ, СЭМТ-д зайлшгүй шаардлагатай хэрэглэгдэхүүн болон зохион байгуулалтын

## ХАВСРАЛТ 2

талаар шалгах хуудсын дагуу шалгана. Байгаа бол (□) гэж байхгүй бол (X) тэмдэглэнэ.

- Үзлэг зохион байгуулах өрөө тасалгаа
- Үзлэгийг тогтмол зохион байгуулах хуваарь, хамрагдах хүүхдийн бүртгэл, хамрагдалтын хувь зэрэг холбогдох бүртгэл, баримт
- Үзлэгт хамрагдаагүй хүүхдийг нөхөж хамруулах зохион байгуулалт
- Багцын жин ажиллаж байгаа эсэх
- Өндөр хэмжигч
- Үзлэг хийхэд шаардлагатай тоглоом, зураг, зурагтай ном
- Үзлэгт эмч нараа хэрхэн зохион байгуулдаг тухай

### 5) Эмч, ажилчидтай ярилцаж асуудлыг шийдвэрлэх

- Эхлээд үзлэгийг сайн зохион байгуулж байгаад баяр хүргэх ба дэмжлэгт хяналт нь үзлэгийн чанарыг сайжруулахад туслах зорилготой гэдгийг тайлбарлана.
- Ажилтнуудад үзлэг зохион байгуулахад тулгардаг асуудлуудын талаар сайтар сонсож, өөрийн ажигласан асуудлыг нэмж нэгтгэнэ.
- Асуудал тус бүрээр нь хэрхэн шийдвэрлэж болох талаар өөрсдөөр нь хэлүүлж хамтран шийдвэрлэнэ.
- АЭМГ, ДЭМТ-ийн түвшинд шийдвэрлэх асуудлуудыг тэмдэглэж, тэдгээр байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

### 6) Дэмжлэгт хяналтын нэгдсэн тайланг бичнэ.

Үүнд дараах зүйлүүдийг тусгана:

- Хяналтын явцад ажиглагдсан сайн талууд болон бэрхшээлүүд
- ӨЭМТ, СЭМТ-ийн хүрээнд шийдвэрлэсэн асуудал
- Дараагийн хяналт хийхэд шаардлагатай дүүрэг, аймаг, сумын түвшинд авах арга хэмжээнүүд
- Хамрагдалтыг сайжруулахад засаг захиргааны байгууллагуудтай хамтрах гэх мэт

Тайлангийн хувийг тухайн ӨЭМТ, СЭМТ-д үлдээнэ.

### 7) АЭМГ, ДЭМТ-д дэмжлэгт хяналтын дүнг танилцуулах

Дэмжлэгт хяналтын дүнг АЭМГ, ДЭМТ-ийн асуудал хариуцсан удирдлага мэргэжилтнүүдэд танилцуулж, үзлэгийн хамрагдалт болон чанарыг сайжруулахад шаардлагатай арга хэмжээ, төлөвлөгөөг хамтран шийднэ.

**ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ЦОГЦ ҮЗЛЭГТ  
ДЭМЖЛЭГТ ХЯНАЛТ ХИЙХ ШАЛГАХ ХУУДАС**

ЭМБ-ын нэр ..... Дэмжлэгт хяналт хийсэн .....он ....сар.....  
өдөр

Сум/ дүүрэг/ хороо..... Хяналт хийж буй ажилтны нэр  
..... /Албан тушаал /

**1. Үзлэгийн зохион байгуулалт**

- 1.1 Үзлэгийн өрөө тасалгаа байгаа тийм \_\_\_\_\_ үгүй \_\_\_\_\_
- 1.2 Хүүхдийг үзэх зай талбай хангалттай тийм \_\_\_\_\_ үгүй \_\_\_\_\_
- 1.3 Сандал ширээ хүрэлцээтэй байгаа тийм \_\_\_\_\_ үгүй \_\_\_\_\_
- 1.4 Хүүхэд асран хамгаалагчтайгаа хүлээлгийн хэсэгт байгаа  
тийм \_\_\_\_\_ үгүй \_\_\_\_\_
- 1.5 Багцын жинтэй /байхгүй бол ямар жин байгааг бичих /  
тийм \_\_\_\_\_ үгүй \_\_\_\_\_
- 1.6 Урт өндөр хэмжигчтэй тийм \_\_\_\_\_ үгүй \_\_\_\_\_
- 1.7 Хүүхдийн хөгжлийг үнэлэхэд шаардлагатай  
тийм \_\_\_\_\_ үгүй \_\_\_\_\_

- Зурагтай ном
- Аяга
- Шүдний сойз (гэрээс нь авчруулах)
- Цэвэр ус, цай гэх мэт уух юм
- Тоглоомнууд

Ямар нэгэн асуудал байвал тэмдэглэж ямар арга хэмжээ авсан болон хэрхэн сайжруулах талаар хэлэлцэн, санал боловсруулж бичнэ.	
Шалгуулж буй эмчид тулгардаг асуудал	Дэмжлэгт хяналтаар очсон ажилтны шийдвэрлэсэн асуудал, туслалцаа

- 1.8 Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх сургалтад хамрагдсан эмч нар  
Сургалтад хамрагдсан эмчийн тоо .....

ХАВСРАЛТ 2

Сургалтад хамрагдсан эмч хангалтгүй бол ӨЭМТ, СЭМТ-ийн удирдлагын зүгээс ямар арга хэмжээ авах талаар ярилцаж төлөвлөнө.	
ӨЭМТ, СЭМТ-ийн зүгээс авах арга хэмжээ, үйл ажиллагаа	Дэмжлэгт хяналтаар очсон ажилтны авсан арга хэмжээ, үзүүлсэн зөвлөгөө, дэмжлэг

1.9 Үзлэгт хамрагдах хүүхдүүдийн нэрсийн жагсаалт бэлэн байгаа тийм \_\_\_ үгүй \_\_\_

**2. Эрүүл мэндийн үзлэгийн чанар**

Эрүүл мэндийн мэргэжилтний нэр .....					
Албан тушаал .....					
<b>2.1 Ажиглалт (Хамгийн багадаа 2 хүүхэд шалгах)</b>		<b>Хүүхэд 1</b>		<b>Хүүхэд 2</b>	
	Үзлэг хийхдээ ЭХЭМД ашиглаж байна уу	тийм	үгүй	тийм	үгүй
<b>2.1.1</b>	Хөх хуудсыг шалгаж тэмдэглэсэн	тийм	үгүй	тийм	үгүй
	Хүүхдийг зөв жинлэж тэмдэглэсэн	тийм	үгүй	тийм	үгүй
	Урт/өндрийг зөв үнэлж тэмдэглэсэн	тийм	үгүй	тийм	үгүй
	<b>2.1.2 Бодит үзлэг ажиглах</b>	тийм	үгүй	тийм	үгүй
	Арьс, үс, хумс	тийм	үгүй	тийм	үгүй
	Цус багадалтын шинж:	тийм	үгүй	тийм	үгүй
	Толгой, хүзүү, захын тунгалгийн булчирхай:	тийм	үгүй	тийм	үгүй
	Яс, булчингийн тогтолцоо:	тийм	үгүй	тийм	үгүй
	Нүд	тийм	үгүй	тийм	үгүй
	Чих, хамар, хоолой	тийм	үгүй	тийм	үгүй
	Сонсгол	тийм	үгүй	тийм	үгүй
	Амьсгалын тогтолцоо	тийм	үгүй	тийм	үгүй
	Зүрх судасны тогтолцоо	тийм	үгүй	тийм	үгүй
	Хоол боловсруулах тогтолцоо	тийм	үгүй	тийм	үгүй
	Шээс бэлгийн тогтолцоо	тийм	үгүй	тийм	үгүй
	Мэдрэлийн эрхтэн тогтолцоо:	тийм	үгүй	тийм	үгүй
	Нүдэнд ил харагдах хөгжлийн гажиг	тийм	үгүй	тийм	үгүй
	Амны хөндий	тийм	үгүй	тийм	үгүй
<b>2.2</b>	<b>Хүүхдийн хөгжлийн үнэлгээг хийхийг ажиглах</b>	тийм	үгүй	тийм	үгүй
	Хүүхэд өөрөө явж чадаж байна уу ? ( ___ нас ___ сартайдаа хөлд орсон)	тийм	үгүй	тийм	үгүй

	Хүүхэд утгатай үг тухайлбал “ээж”, “аав” гэх мэт үг хэлж байна уу ?	тийм	үгүй	тийм	үгүй
	Аяганаас өөрөө ууж чадаж байна уу ?	тийм	үгүй	тийм	үгүй
	Хүүхэд угжаар уусаар байна уу? (шүд цоорохоос сэргийлэх зорилгоор угжаар уухыг зогсоох хэрэгтэй)	тийм	үгүй	тийм	үгүй
	Хүүхэд цагаар хооллодог уу?	тийм	үгүй	тийм	үгүй
	Хүүхдийн нүд нь ер бусын хөдлөх, эсвэл гэрэлд хэт их мэдрэмтгий байдаг уу <sup>3</sup> ?	тийм	үгүй	тийм	үгүй
	Хүүхэд хүний нүд рүү эгцэлж харж чадаж байна уу ?	тийм	үгүй	тийм	үгүй
	Хүүхдийг араас нь нэрээр нь дуудахад эргэж хардаг уу?	тийм	үгүй	тийм	үгүй
	Хүүхдэд шүдээ угаахыг зааж өгөхөд дуурайж угааж чаддаг уу?	тийм	үгүй	тийм	үгүй
	Таны хүүхэд юу хийх, оролдох дуртай вэ? Жишээ нь: .....				
	Хүүхдээс мэддэг юмыг нь асуухад хуруугаараа зааж чадаж байна уу?	тийм	үгүй	тийм	үгүй
	Өөрийн биеийн эрхтнүүдийг мэддэг үү? Тухайлбал амаа ангай, хэлээ гарга гэх мэт	тийм	үгүй	тийм	үгүй
	Хүүхэдтэй хамт байхдаа тэдэнтэй хамтдаа тоглодог уу?	тийм	үгүй	тийм	үгүй
	Танил хүмүүстэйгээ ярилцах дуртай юу?	тийм	үгүй	тийм	үгүй
	Тэврэхэд хариуд нь бас тэвэрнэ.	тийм	үгүй	тийм	үгүй
	Өөртэй нь тоглоход инээнэ, ход ход инээнэ.	тийм	үгүй	тийм	үгүй
<b>2.3</b>	<b>Асран хамгаалагчтай ярилцах</b>				
<b>2.3.1</b>	Та үзлэгт оруулсандаа сэтгэл ханамжтай байна уу	тийм	үгүй	тийм	үгүй
<b>2.3.2</b>	Эмчийн өгсөн зөвлөгөөг ойлгосон уу	тийм	үгүй	тийм	үгүй
<b>2.3.3</b>	Та хэдийд хүүхдээ дахин үзүүлэх вэ ?				
<b>2.4</b>	<b>Асран хамгаалагчид өгсөн зөвлөгөө</b>				
<b>2.4.1</b>	Нарийн мэргэжлийн эмч/эмнэлэгт хандах талаар зөв зөвлөсөн үү?	тийм	үгүй	тийм	үгүй
<b>2.4.2</b>	Асран хамгаалагчид зөв зөвлөсөн үү	тийм	үгүй	тийм	үгүй

<sup>3</sup> Хэрэв хүүхэд гэрэлд хэт мэдрэмтгий, эсвэл нүдээ хагас анисан, эсвэл хүзүүгээ гилжсийж хазайж зурагт үздэг бол харааны гажигтай байж болзошгүй



ХАВСРАЛТ 2

2.4.3	2.4.1 ба 2.4.2-ыг “үгүй” гэж бөглөсөн бол тайлбар хийнэ үү.				
-------	---	--	--	--	--

<b>Ажиглалтын явцад гарсан сайн туршлага болон алдаа</b>	
<p>Ажиглалтын явцад гарсан сайн туршлага болон алдаа сул талыг үзлэг хийсэн эмчид хэлж, яаж зөв хийх талаар зааж өгнө. Үзлэг болон хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн үнэлгээ хийхэд ямар нэгэн бэрхшээлтэй асуудал байвал тодруулж, асуудлыг хэрхэн шийдвэрлэх, ур чадварыг хэрхэн сайжруулах талаар ярилцана.</p>	
<p>Шалгуулж буй эмчийн зүгээс засаж сайжруулах ажлууд</p>	<p>Дэмжлэгт хяналтаар очсон ажилтны авсан арга хэмжээ, үзүүлсэн зөвлөгөө, дэмжлэг</p>

## **ХАВСРАЛТ 3.**

---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан  
тушаал

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД,  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

2018 оны 11 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар А/ЗОН, А/699, А/460

Улаанбаатар  
хот

**Заавар, маягт батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн 3.1.3.3 болон 3.2.2.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх зааврыг нэгдүгээр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрийн маягтыг хоёрдугаар, Хүүхдийн хувийн хэрэг хөтлөх маягтыг гуравдугаар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэлийн маягтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Өрх, сумын эрүүл мэндийн төвд 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг тогтмол зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

3. Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг оношлох, үнэлэх, төрөлжсөн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг лавлагаа төвүүд болон Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, Дүүргийн эрүүл мэндийн төвүүд болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга захирал нарт тус тус даалгасугай.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролд тэгш хамруулах, цэцэрлэг сургуульд хамрагдалтыг сайжруулахад мэргэжил арга зүй, хүний нөөц, тохируулгат орчныг бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудад тус тус даалгасугай.

5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр ханган хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисст даалгасугай.

6. Зааварт холбогдох маягтуудыг боловсруулж, албажуулан нэгдсэн бүртгэл мэдээллийн санд оруулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар (С.Тунгалагтамир), Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газар (Т.Ням-Очир), Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар (Б.Дуламжав), Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газар (М.Баттүвшин)-т тус тус үүрэг болгосугай.

8. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамдын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус үүрэг болгосугай.

9. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд (хуучин нэрээр), Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд (хуучин нэрээр), Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/05, А/14, 16 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцугай.

